# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

*2024.12.10*

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

***Зорилго: Хүн амын эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.***

2024.12.10

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| ***Зорилт 1. Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах*** | | | | | | | |
| 1.1.1 | Аймгийн Эрүүл мэндийн салбар зөвлөлийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллана | - | -Хурлын тоо<br>-Гарсан зөвлөмж | - | Хурал-1<br>Зөвлөмжийн тоо | Дархан-Уул аймгийн засаг даргын зөвлөлийн хуралд 3 удаа , хэлтэс агентлагийн дарга нарын хуралд 1 удаа оролцож эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээний өнөөгийн байдлын талаар танилцуулсан ба шийдвэрлүүлсэн арга хэмжээ 2 байна.<br>Эрүүл мэндийн газрын даргын зөвлөл 7 удаа хуралдаж 24 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна. | 70% |
| 1.1.2 | “Эрүүл идэвхтэй амьдрал”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Элэг бүтэн Монгол”, ”Орчны эрүүл мэнд” “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх” “Эрүүл шүд" арга | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | 8 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 91.4%-тай байна. | 10 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93% | Эрүүл мэндийн чиглэлээр 14 арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжиж байна. Үүнээс:<br>1. Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 5 зорилт 23 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилт 93%<br>2. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ нь 5 зорилт 38 үйл ажиллагааг төлөвллөн хэрэгжилт 87 % | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний хэрэгжилтийг идэвхжүүлж ажиллана | | | | | 3. Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө 5 зорилтын хүрээнд 51 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт 93.6%<br>4. Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн А/816 дугаар тушаалын дагуу “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт 94.3%-тай байна<br>5. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт 92,3 %<br>6. Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 94,1% тай байна.<br>7. ”Орчны эрүүл мэнд” арга хэмжээний хэрэгжилт 87%<br>8. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх” арга хэмжээ 7 зорилт 59 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Хэрэгжилт 96%<br>9. Эрүүл шүд арга хэмжээний хэрэгжилт 97.1%<br><br>2024-2027 онд хэрэгжүүлэх Сэтгэцийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгаалал, Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх, сэргийлэх, Иргэний эрүүл мэндийн боловсрол зэрэг 4 арга хэмжээний төлөвлөгөө шинээр батлагдан ирсэн.<br>Нийт 14 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 93.1% байна. | |
| 1.1.3 | Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулна. | - | Хамтран ажилласан байгууллага, иргэдийн тоо | 512 | 1000 | 2024 оныг Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласантай холбоотой аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвөлгөөнд Нийгмийн эрүүл мэндийн мэндийн тухай хууль болон арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан.<br><br>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Дархан-Уул аймгийн Явган алхалтын холбоо, Дархан-Уул аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газартай | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран DARKHAN WALKING FESTIVAL зохион байгуулж 624 албан хаагч хамрагдсан.<br><br>Эрүүл шүд арга хэмжжэний хэрэгжилтийг ханган хувийн хэвшлийн 15 шүдний эмнэлгүүдийн захиралуудтай эрсдэлтэй өрхийн 98 хүүхдийн шүдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Гарц арга хэмжээний хүрээнд 9 хувийн эмэгтэйчүүдийн эмнэлэгтэй хамтран 324 зориотот бүлгийн эмэгтэйчүүдэд үзлэг шинжилгээ хийж эмчлэн эрүүлжүүлэн ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дунд "ШУГАМАН БҮЖГИЙН ТЭМЦЭЭН"-ийг зохион байгуулж нийт 19 байгууллагын 192 албан хаагчид оролцсон. Монгол улсын Засгийн газрын 2001 оны тогтоол "Нийгмийн эрүүл мэндийн нэрэмжит өдрийг 21 удаа, өдөрлөг 26 удаа, аян 14 удаа зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд 26563 хүнийг хамруулсан байна. | |
| 1.1.4 | Бүх нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг сурталчлах аяныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран насны онцлог бүрт тохирсон хэлбэрээр зохион байгуулна | 500.000 | Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан хүний тоо | 1311 | 2500 | • "Энэ жилдээ, эрүүл жиндээ 2","Бүх нийтийн соёлын боловсрол", "Нийтийн биеийн тамирыг дэмжих жил", аяны хүрээнд Аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Соёл, урлагийн газар, Дархан Биеийн тамир, спортын газар, Нийтийн бүжгийн "Ирээдүй" холбоо хамтран Дархан-Уул Аймгийн Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дунд "ШУГАМАН БҮЖГИЙН ТЭМЦЭЭН"-ийг зохион байгуулж нийт 19 байгууллагын 192 албан хаагчид оролцсон.<br>• Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамж , Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын 15-64-н насны 14 байгууллагын 692 эмч эмнэлгийн ажилчдыг бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулсан. Бие бялдрын түвшин тогтоох сорилд эрэгтэй-577/83%, эмэгтэй -119/17% байна. Бие бялдарын үнэлгээ: А- 298/43%, В -222/32% , С- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 128/18.4%, D- 36/5.2%, F-8/1.1% байна.Биеийн жингийн индексийг үзэхэд туранхай – 16 буюу 2.3%, Хэвийн – 316 буюу 45.6%, Илүүдэл жинтэй – 232 буюу 33.5%, 1-р зэргийн таргалалт – 101 буюу 14.6%, 2-р зэргийн таргалалт – 19 буюу 2.7% Хэт тарган -8 буюу 1.1%-ийг тус тус эзэлж байна.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Дархан-Уул аймгийн Явган алхалтын холбоо, Дархан-Уул аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газартай хамтран DARKHAN WALKING FESTIVAL Монгол улсад анх удаагаа явган алхалтын замын Олон улсын тэмдэг, тэмдэглэгээний стандарт нэвтрүүлсэн хот болж олон нийтэд сурталчлан таниулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дасгал хөдөлгөөнийг дадал болгоход уриалах зорилгоор 17 ААНБ-ын 624 ажилтан албан хаагчид, иргэд оролцсон. Эрүүл мэндийн салбараа төлөөлөн 90 ажилтан албан хаагчид оролцож 10000км, 50000км алхалт хийж Алхалтын сертификатаа гардан авсан. ЭМБ-ууд спортын арга хэмжээг 4 төрлөөр зохион байгуулж 340 гаруй албан хаагчид хамрагдсан байна. Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр ЭМГ, НЭ, Гос хот ӨЭМТ хамтран “Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2” аянтай холбогдуулан “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя" өглөөний алхалтанд 12 байгууллагын 298 ажилтан албан хаагчид оролцсон. “Илүүдэл жингүй эртэч Монгол цаг гаргая” өглөөний дасгалд ЭМБ-аас 300 гаруй ажилтан хамрагдсан. "АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САР"-ЫГ ТОХИОЛДУУЛАН" ахмадын алхалт, дасгал"-ын үйл ажиллагааг зохион байгуулж 35 ахмад хамрагдсан.<br>“Энэ жилдээ- Эрүүл жиндээ 2” аяны хүрээнд Дархан SKY фитнесс төвтэй хамтран ЭМБ-ын ажилчдыг 30% хөнгөлттэй үнээр 30 ажилтан дасгалаар хичээллэж байна. Эрүүл мэндийн газрын чийрэгжүүлэх зааланд 3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 1-ээс  өдөр бүр  18-25 ахмадууд ирж дасгал хөдөлгөөн тогтмол хийж байна. | |
| 1.1.5 | Жирэмсэн, хөхүүл ээж нарт чиглэсэн эсэн мэнд амаржихуй, нярайн асаргаа сувилгаа, дасгал хөдөлгөөн, хооллолт цахим цуврал зөвлөгөө, сургалт зохион байгуулна | 500 мян | Сургалтад хамрагдсан жирэмсэн болон хөхүүл ээж | Сургалтад 876 | 900 | “Эсэн мэнд амаржихуй” цуврал сургалт, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинет, Нэгдсэн эмнэлгийн өндөр өртөмгий жирэмсний хяналтын кабинетад тус тус хяналтанд орсон эхчүүд, ээжүүдэд, 7 хоног бүр тодорхой сэдвийн хүрээнд урьдчилан цаг зарлан мэдээлэл түгээж,  “Жирэмсэн, хөхүүл ээж нарт чиглэсэн Эсэн мэнд амаржихуй, нярайн асаргаа сувилгаа, дасгал хөдөлгөөн,эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол, ангир уурах амлуулах нь” сэдвүүдээр сургалтыг 35 удаа зохион байгуулж давхардсан тоогор 903 жирэмсэн, хөхүүл эхчүүд болон залуу аав нар хамрагдсан  байна. | 100% |
| 1.1.6 | “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг бусад салбар нэгжийн оролцоог ханган зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Сургалтын төрөл, хамрагдсан иргэдийн тоо | Нэрэмжит өдөр 16, удаа, Нэвтрүүлэг-32, аян 14, өдөрлөг 23, 17 сувгаар 87 зөвлөмж, Контент 10 | Стандартын шаардлага хангасан мэдээ, нэвтрүүлэг-12 контент-10 Лайв-20 | Монгол Улсын засгийн газраас Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй 14 арга хэмжээний хүрээнд  нийт 228 аж ахуй нэгж, байгууллагын ажилтан албан хаагч, 26 ЕБС, 31 СӨБ,  9 их дээд сургуулийн оюутан залууст 524 удаагийн сургалтаар ***19724***  хамруулан эрүүл мэндийн боловсрол олгосон байна.  “Эрсдэлгүй Дархан” аяны хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал, чадвар эзэмшүүлэх зорилготой “Үе тэнгийн-ээрэг нөлөөлөгч” сургагч багш бэлтгэх тусгай хөтөлбөрийг Дархан-Уул аймгийн 25 ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдад зориулан Боловсрол шинжлэх ухааны газар, Аймгийн эрүүл мэндийн газар,  Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар хамтран зохион байгуулж 715 сурагчдыг  “Өсвөр насны үе тэнгийн сургагч”-аар бэлтгэж, гэрчилгээ гардуулсан.<br><br>Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй үйл ажиллагааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 321 мэдээ, 25 Эрүүл мэндийн нэвтрүүлэг, видео зөвлөмж 32, 10 контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна. | |
| 1.1.7 | “Тамхигүй сургууль”, “Тамхигүй байгууллага” “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” аян зохион байгуулна. | 1 сая | Оролцсон байгууллагын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо Бэлтгэгдсэн үе тэнгийн сургагчийн тоо | 1200 сурагч<br>128 оюутан | Тамхигүй сургууль” “Тамхигүй байгууллага” “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” 1-2<br>-Үе тэнгийн сургагч 30 Сургалтад 1500 | “Тамхигүй өсвөр үе” аяны хүрээнд Утаат, электрон тамхины хор уршиг сэдвээр сургалтыг ерөнхий боловсролын 10 сургуулийн сурагчид болон оюутан 3072, 12 ААНБ-ын 600 гаруй албан хаачид хамрагдсан. АХА тэмцээнийг Монгол-Оюу, Шинэ алхам сургуулийн 8-11-р ангийн 386 сурагчдын дунд зохион байгуулсан .<br>Дэлхийн тамхигүй өдрийг “Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж, “Үе тэнгийн-эерэг нөлөөлөгч” сургагч багш бэлтгэх тусгай хөтөлбөрийг Дархан-Уул аймгийн 25 ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 391 бүлгийн 715 сурагчдыг Боловсрол шинжлэх ухааны газар, Аймгийн эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар хамтран зохион байгуулсан. | 100% |
| 1.1.8 | Оюутан залууст чиглэсэн Гэр бүл төлөвлөлт, БЗДХ, амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх талаар сургалт, сурталчилгаа, уулзалт зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна | - | -Сургалт, сурталчилгаа, үзлэгт хамрагдсан оюутан залуусын тоо | -7756 | 7800 | • Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвөөс Халдварт болон Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлье сургалтыг Явуулын 2 багаар 9 их дээд сургуулийн 3689 оюутан залууст зохион байгуулсан.<br>• Халдварт өвчний ерөнхий ойлголт, Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх, Дархлаажуулалт, Сүрьеэ, БЗДХӨ/ХДХВ-аас халдвараас сэргийлэх сургалтыг аж ахуйн нэгж байгууллага, оюутан сурагчдад зохион байгуулж нийт 1043 ажилтан, албан хаагч, оюутнууд хамрагдсан байна.<br>Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв дадал бий болгох зорилгоор "Алхалтад цаг гаргая " уриатайгаар Эрүүл мэндийн газар, өрх, сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн 120 гаруй эмч мэргэжилтнүүд, 9 их дээд сургуулийн 76 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оюутан залуусыг хамруулсан өглөөний дасгал, алхалт арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу эрт илрүүлэг үзлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн судалгаанд үндэслэн 0-17 насны 201 хүүхдүүдийг эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоонд хамруулсан.<br><br>Хууль хүчний байгууллага ,Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн албан хаагч 263, 2024 оны Оюутан цэргийн албанд татагдаж буй 120 залуучууд, 2024 оны 1,2-р ээлжийн цэргийн жинхэнэ албанд татагдаж байгаа 983 цэргийн насны залуучууд, ААНБ-ын 714 албан хаагч эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.<br><br>ХӨСҮТ ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс боловсруулсан цахим зөвлөмжийг 12 төрлөөр, орон нутгийн хэвлэл мэдээлэл, цахим сайтын 3 сувгаар 15 төрлийн шторк байршуулж, хандсан хүний тоо 1847 байна. Танхимын сургалтын үр дүнд оюутан залуусын мэдлэгийн түвшин 28%-иар нэмэгдсэн байна. | |
| 1.1.9 | “Эрүүл шүд" арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана | 500.000 | -Сургалтад хамрагдсан хүүхдийн тоо<br>-Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | - | 5000 | • Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024.01.19-ны өдрийн “Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхээр орон нутгийн онцлогт тохируулж 6 зорилт 27 арга хэмжээ төлөвлөн ажиллаж байна.<br>• Монгол Оюу сургууль, Цайхун сургууль, Шарын гол сумын ерөнхий боловсролын 6-р сургууль “Шүд угаах цаг” гарган хэрэгжүүлж эхэлсэн. Дархан-Уул аймгийн ЗДТГ, АШУҮИС-ын Дархан салбар сургууль хамтран “Эрхэм баян-Эрүүл мэнд” Нүүр ам судлалын шүдний хувийн эмнэлгүүдийн эмч нарын баг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд, Ерөнхий боловсролын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн эмч нарт Шүдний эрүүл ахуй, эмчилгээ оношлогоо сургалтыг зохион байгуулсан. Иргэдэд үнэ төлбөргүй шүдний үзлэг, зөвлөгөө, эмчилгээг АШУҮИС-ын Дархан салбар сургуулийн Нүүр Ам Судлалын сургуулийн эмч багш нар шүд цоорлын эмчилгээ, цоорол зогсоох түрхлэг, шүд эрдэсжүүлэх түрхлэг, шүд авах эмчилгээ тус тус хийсэн.<br>“Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд шүд, нүүр амны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 хувийн эмнэлгийн захирлуудтай Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг байгуулж зорилтот бүлгийн хүүхдийн судалгааг гарган 98 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн. ХХЭМБ-аар шүдний үзлэгт 24311 хүүхэд үзүүлж,оношилгоо, эмчилгээнд орсон байна. Хүүхдэд тохиолдох А бүлгийн В стрептококкийн гаралтай ангина, фарингит, хүүхдийн хэрэх өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажиг өвчлөлийн хувийг бууруулах зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сан, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭМГ хамтран Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн эмч нар болон эцэг эхчүүдэд мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. 6-17 насны хүүхдэд стрептококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 26133 хүүхдээс 24690 /90.6%/ хүүхдийг хамруулж 2239 /9%/ хүүхэд зэрэг илэрсэн ба тэдгээрийг дараагийн шатлалын эмчилгээнд хамруулж ажиллахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. | |
| 1.1.10 | Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансуурулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар мэдлэг олгох үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 500.000 | -Зохион байгуулсан үйл ажиллагаа<br>-Хамрагдсан хүний тоо | 1184 | 2000 | Нэгдсэн эмнэлэгийн сэтгэцийн тасгаар үйлчлүүлэгчид зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгээс сэргийлэх сургалтыг давхардсан тоогоор 713 үйлчлүүлэгч хамрагдсан.<br>Сэтгэцийн тасгаас 15-64 насны хүмүүсийн архины хэрэглээний түвшинг тодорхойлох судалгааг эхлүүлж, AUDIT асуумжийн аргаар 237 үйлчлүүлэгчээс асуумж судалгаа авсан. Эрүүл мэндийн анхан шатны тусламж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ болон амбулаториор үйлчлүүлж буй 1046, их дээд сургуулийн 639 оюутанд мансууруулах бодисын хор нөлөө, архи, тамхины хор уршиг зэрэг сэдвээр сургалт, зөвөлгөө зохион байгуулсан | |
| 1.1.11 | Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2-3 эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн сайжруулж ажиллана. | - | Шинэчлэн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоо | - | 1-2 | 2 Эрүүл мэндийн байгууллагын 00 ариун цэврийн өрөөг сайжруулан шинэчилсэн. Дэлхийн 00-ын өдрийг ЕБС-ийн орчинд аюулгүй стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болохыг уриалан нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>2024 оны урьдчилан сэргийлэх шалгалтаар Дархан ус суваг ХК-ийн төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин 85%-тай, өмнөх оноос 5%-иар буурсан, Дулаан шарын гол ТӨХК-ийн цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин 72%-тай өмнөх оны үзүүлэлтээс 16%-иар нэмэгдсэн, Эмт наран ОНӨААТҮГ- ын цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин 67%- тай өмнөх оны үзүүлэлтээс 2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй, Салхит өртөөний цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин 60%-тай болж өмнөх оны үзүүлэлтээс 10%-иар буурсан байна. | 100 |
| 1.1.12 | Хавдрын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлж, болзолт уралдаан, аян өрнүүлэн ажиллана. | 500.000 | -Зохион байгуулсан үйл ажиллагаа, -хэрэгжилтийн хувь | 5 зорилт, 51 арга хэмжээ 94.6%, | Арга хэмжээний хэрэгжилтийн 95% | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/360 дугаар тушаалын дагуу “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээний хэрэгжилт 93.6%-тай байна. ХСҮТ, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу Хавдрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад удирдах ажилтануудын оролцоо, хавдрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амд үзүүлдэг эмч мэргэжилтнүүдийн уялдаа “Фокус ярилцлага”-ыг 20 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, Хавдартай иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хими эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөнгөвчлөх эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээ авах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, Хавдартай иргэдийн гэр бүлийн гишүүдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, Нэгдсэн эмнэлгийн бусад тасаг Өрх, Сумын эрүүл мэндийн төв Хавдартай иргэдэд тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан.<br><br>Эмч бүр хавдрын эсрэг хувь нэмрээ оруулья болзолт уралдаан, аяны хүрээнд ЭМГ-ын зөвлөлийн хурлаар Хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах хими эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж тусламж үйлчилгээ чанартай үзүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. “Ягаан тууз” мэдээлэл нөлөөллийн арга хэмжээнд хөхний хавдрын талаарх мэдээлэлийг 418 хүнд хүргэсэн.<br><br>Хорт хавдрын өнөөгийн байдал, Хавдраас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлье зэрэг сэдвүүдээр сургалтад 11 албан байгууллагын 824 ажилтан, албан хаагч, ЕБС, СӨБ-ын эмч, тогооч, ажилчид зэрэг нийт 254 хүнд сургалт хийсэн.<br><br>Хөнгөвчлөх тасаг 8 ортойгоор 341 хүнд хөнгөвчлөх эмчилгээ, 14 хүнд хими эмчилгээ хийж тусламж үйлчилгээ үзүүлж байна. 2024 онд хавдрын хими эмчилгээний мэргэжил олгох сургалтанд 1 эмч хамрагдсан. Хавдрын үзүүлэлт 2024 оны 10 сарын байдлаар: Хорт хавдрын шинэ тохиолдол 283. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 тохиолдлоор нэмэгдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын тоо 178. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 тохиолдлоор нэмэгдсэн. Хорт хавдрын шинэ тохиолдлын 20.4% эрт үедээ, 79.6% хожуу үедээ оношлогдсон. 1236 иргэн хавдрын хяналтанд байна. | |
| 1.1.13 | Харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана | - | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан иргэд - хэрэгжилтийн хувь | 15 удаа сургалт, 7622 хамрагдсан. Хэрэгжилт 96.5% | 5000 хүн хэрэгжилтийн хувь 96.5 | • Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн А/816 дугаар тушаалын дагуу “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт 94.3%-тай байна.<br>• “Харшлаас сэргийлэх эмчийн зөвөлгөө” сургалт, мэдээллийг ӨЭМТ, СЭМТ-ийн төвтэй хамтран 34 удаа өсвөр нас, оюутан залуус, албан хаагчид 2476 хүнийг хамруулсан байна.<br>“Та антибиотик, харшлын эмийг зохистой хэрэглэдэг үү” цахим судалгаанд 2235 иргэн оролцсон ба 57% нь мэдлэгийн түвшин хангалттай, 12% нь дунд зэрэг мэдлэгтэй, 31% нь хангалтгүй гэж гарсан байна. Олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгслэл ,сошиал-аар иргэдэд АӨСҮТ, НЭМҮТ-өөс гаргасан сурталчилгаа, зөвлөмж, мэдээллийгийг 8 удаа хийж, 2098 иргэний хандалт авсан.<br><br>Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд харшил үүсгэгч хүнсний бүтээгдэхүүн, шошго, тэмдэг, тэмдэглэгээний талаар сургалтыг хүнс болон худалдаа үйлчилгээний 53 байгууллагын 1094 үйлчилгээний ажилтанд зохион байгуулсан. Амьтны үс, арьснаас халдварлагдсан харшил, түүнээс сэргийлэх 5 төрлийн зөвлөмжийг боловсруулж, мал эмнэлэг, амьтны 2 дэлгүүрийн 12 худалдагчид зөвөлгөөг өгч сургалт сурталчилгааны материал тараасан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Урьдчилан сэргийлэх арьс харшлын эмчийн үзлэгт их дээд сургуулиуд, коллеж, ЕБС, аж ахуй байгууллагын 5024 ажилтан албан хаагчдыг хамруулсан. | |
| 1.1.14 | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өвчлөлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа Хамрагдсан иргэд Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 8 байгууллага сургалтад 3437 хүн хамрагдсан. Хэрэгжилт 91.6% | 2500 хүн хамрагдах, Арга хэмжээний хэрэгжилтийн хувь 92 | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ны өдрийн А/559 дугаар тушаалын дагуу “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээний хэрэгжилт 92.3%-тай байна.<br>Эрчүүдийн эрүүл мэндийн онцлог, Осол гэмтлээс сэргийлье, Хорт зуршил ба эрүүл мэнд, БЗДХ-аас сэргийлье зэрэг сэдвээр сургалтыг Политехникийн коллеж, ХААИС, ШУТИС зэрэг их дээд сургуулиуд, Хууль сахиулах байгууллагууд, Зэвсэгт хүчний анги нэгтгэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, бие бүрэлдэхүүн, Нийтийн тээврийн жолооч нийт 3021 хүнийг хамруулсан байна.<br>Нэгдсэн эмнэлгийн эрэгтэйчүүдийн кабинетаар 528 хүнд үзлэг хийснээс түрүү булчирхайн томролыг дурангаар зүсч авах хагалгааг 29 , шээлгүүрт стент тавих хагалгаа 1, давсганд гуурс байрлуулах хагалгаа 2 хийж нийт 32 хагалгаа хийсэн. | 90 |
| 1.1.15 | Элэг бүтэн Монгол арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа Хамрагдсан иргэд Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 94.5% | 95% | Элэг бүтэн Монгол арга хэмжээ 4 зорилт, 19 үйл ажиллагааны хэрэгжилт 94.1% байна.<br>Элэгний хорт хавдраас сэргийлье Элэгний B,C вирусын илрүүлэг, эмчилгээ оношлогоо зэрэг сэдвүүдээр сургалтыг 2253 хүнд хийсэн.<br>Элэг бүтэн Монгол арга хэмжээний хүрээнд 2021-2024 онд зорилтот бүлгийн 15-аас дээш насны 70894 иргэн элэгний хавдрын эрт илрүүлэгт хамрагдахаас 64211 буюу 84.6% тай байна. 2024 онд B,C вирусын шинжилгээнд 15-аас дээш насны 9045 хүн хамрагдсан. Үүнээс B вирус илэрсэн 318 иргэдээс ачаалал тоолох шинжилгээнд 148 илгээж идэвхжилтэй 88 иргэнг эмчийн хяналтад авсан байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 147 хүнд С вирус эерэг илрэн ачаалал тоолох шинжилгээнд хамрагдаж 81 иргэн С вирусийн эсрэг эмчилгээнд орсон байна.<br><br>Элэгний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 40-65 насны нийт -29316 иргэн хамрагдахаас 26561 буюу 86.9 % хамрагдсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9% иар буурсан байна.<br><br>“Дархан-Уул аймагт 2018-2022 онд бүртгэгдсэн хавдрын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээ” судалгаа хийж эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцсон. | |
| 1.1.16 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчныг тохижуулах арга хэмжээ хэрэгжүүлж ажиллана | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа Хамрагдсан иргэд Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 12 эмнэлэгт хяналт үнэлгээ хийсэн. Хэрэгжилт 90% | 10 ЭМБ | “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар 5 өрх, 3 сум, Нэгдсэн эмнэлгээс холбогдох 29 заалтын хүрээнд санал авч ЭМЯ-д хүргүүлсэн. Аймгийн ЗДТГ-ын 2-10/548 албан тоотын дагуу ЭМГ-ын даргын 2024 оны А/87 тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 144, МУЗГ-ын 2022 оны 253 тогтоол, MNS 6055:2009 5682:2006 6056:2009 стандартын хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн гадна, дотно орц, гарц, 00 өрөөг стандартад нийцсэн эсэхэд Орхон, Хонгор, Шарын гол, Түвшин холбоо, Аминхолбоо, Гэрэлтэй, Госхот, Мэдстоп ӨЭМТөвүүдэд тусгайлсан үнэлгээ хийсэн. Дархан-Уул аймагт Эрүүл мэндийн 10 байгууллагад 41 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллаж Хөдөлмөрийн тухай хуулийн 144 заалтыг хэрэгжүүлсэн байна. Дохио хэлний сургалтад 3 ажилтан хамрагдсан. “Хамтдаа хөгжье” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээний талаарх хэлэлцүүлэгт хамрагдсан эцэг эхчүүдийн даун болон аутизмтэй хүүхдүүдэд шүдний урьдчилан сэргийлэх, оношлох үзлэг зохион байгуулж 20 хүүхэд хамрагдсан. ХБХ салбар комисс 123 удаа | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуралдаж 375 хүүхдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Аймгийн ХБХХТ "Тэгш хөгжье" нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | |
| **Зорилт 2. Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлөх шинэ сорилт болзошгүй цар тахал нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг нэмэгдүүлж, олон салбарын оролцоог хангах, халдварт өвчний тандалт хяналтын тогтолцоог бэхжүүлэх** | | | | | | | |
| 2.1.1 | Томуугийн харуулдан тандалтын үйл ажиллагааг бэхжүүлж, эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллана. | - | -Сорьц тээвэрлэсэн байдал Нөөцийн бэлэн байдал | 1-2 сарын нөөц | 1-2 сарын нөөцтэй байх | Томуугийн интернэтэд суурилсан тандалтын тоо мэдээг 46 долоо хоногийн турш долоо хоног бүрээр нэгтгэн оруулсан байна. Нэгдсэн эмнэлэг, өрх, сумдын эрүүл мэндийн төвүүд томуугийн мэдээг 100% хугацаандаа өгсөн байна.<br><br>2024 оны 46-р долоо хоногийн томуугийн матриц үнэлгээгээр ТТӨ –74.4 АЗЦХХ- 10.0 промилл буюу АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ҮЕ дээр байна. Өнгөрсөн долоо хоногтой харьцуулахад амбулаторийн өвчлөл 8.1 промиллоор, эмнэлэгт хэвтэлт 3.4 промиллоор өссөн байн<br><br>Улирлын томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээний босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоож үнэлгээг 7 хоног бүр хийж ХӨСҮТ-д мэдээлж, эргэн мэдээллээр бүх нэгжүүдээ хангах хариу арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Нэгдсэн эмнэлгийн вирус судлалын лабораторид ТТӨ-ний шинжилгээ 473 хийгдсэнээс эерэг тохиолдол 28 илэрсэн байна. ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид 54 сорьц илгээсэн ба бүх сорьц баталгаажсан байна | 100% |
| 2.1.2 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн Эрүүл мэндийн байгууллагын тогтвортой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 200 мян | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь. | 90 | 90 | Халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийг бууруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор зөвөлгөөнийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтэн 36 хүн оролцсон. Аймгийн Цэргийн штабаас зохион байгуулсан 3 хоногийн "Орон нутгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалт”-ыг Хонгор сумын Зулгагын голд Дархан сумын ЗДТГ, ОБГ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран оролцсон. Сургалтын үеэр ЭМГ-аас удирдах бүрэлдэхүүнд оролцон газар хөдлөлтийн цагийн байдал дээр хариу арга хэмжээг төлөвлөн ажиллахаас гадна ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Орхон, Хонгор, Шарын гол сумдын эмч, мэргэжилтэнүүд яаралтай тусламжийн хээрийн эмнэлэг дэлгэн ажилласан | |
| 2.1.3 | Тархвар судлал, сайн дурын дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ | - | Дархлаажуулалтын хувь | 99 | 99% | Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт ВГВ-ын эсрэг дархлаажуулалтыг төрсөний дараа 24 цагийн дотор нийт 1393 хүүхдэд , В вирусын халдвартай 9 эх төрсөн ба нярайд гепатит В вирусын эсрэг иммуноглобулинд 3 нярай хамрагдсан. В гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 970 иргэн хамрагдсан байна.<br>Улаанбурхан, улаануудын эсрэг сэргийлэх тарилгад 4305 иргэн хамруулсан.<br>Тархвар судлалын заалтаар: Галзуугийн эсрэг дархлаажуулалтад 81 хүн, хачигт энцефалитын эсрэг дархлаажуулалтад 200 хүн хамрагдсан. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй.<br><br>Товлолт дархлаажуулалтын хамралт 99.6% байна. | 100% |
| **Зорилт 3. Олон нийт, иргэний нийгмийн оролцоотой сүрьеэгийн цогц чанартай тусламж үйлчилгээг хүн амд тасралтгүй хүртээмжтэй хүргэх** | | | | | | | |
| 3.1.1 | Зорилтот бүлгийн иргэдэд сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг, үзлэг шинжилгээг зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. | 3 сая | Сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамрагдсан эрсдэлт бүлгийн иргэд | Үзлэгт 2711 хамрагдсан. Шинээр 23 хяналтад авсан. | 2000 | • Орон гэргүй “Түр байршуулах байранд байгаа болон архины хамааралтай 43 иргэдэд үзлэг хийн 20 сэжигтэй тохиолдлоос халдвартай 1, булчирхайн сүрьеэ 1 илрүүлж эмчилгээ хяналтад авсан.<br>• Цас зудын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор 18-р багийн малчин 172 хүнд уушигны эмгэг илрүүлэх үзлэг хийж 6 сэжигтэй тохиолдлоос сорьц авсан. Хавдар 1 оношлон дээд шатанд илгээж, 6 хүнд эмчилгээ, 2 хүнийг уушигны хатгалгаа оношлон хэвтүүлэн эмчилсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн газрын даргын батлагдсан удирдамжийн дагуу Сүрьеэгийн явуулын үзлэгийн зохион байгуулж, Зорилтот болон эрсдэлт бүлгийн 1518 хүнд хийж 91 сэжигтэй тохиолдлоос 8 сүрьеэг илрүүлэн эмчилгээ хяналтанд авсан.<br>• 2024 оны I ээлжийн цэрэг татлагын эрчүүдэд үзлэг хийн 86 хүнд цээжний зураг 2 хүнээс шинжилгээ авч цэргээс түр чөлөөлсөн.<br>• Шарын гол Бетон шон үйлдвэрийн газрын 20 хүнд үзлэг хийж, урьд нь өвчилж байсан 2 хүнээс сорьц авч дахилтаас сэргийлэх талаар ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.<br>• Жаргалтай амьдрал төвийн 40 хүнд үзлэг хийж 8 сэжигтэй тохиолдлоос 1 сүрьеэг илрүүлэн эмчилгээ хяналтанд авсан.<br><br>Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн хурлаар Сүрьеэгийн өнөөгийн байдал, цаашдын чиглэл сэдвээр хэлэлцүүлсэн. | 100% |
| 3.1.2 | Сүрьеэгийн далд халдвартай тохиолдлын эмчилгээнд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ | - | Хамрагдалтын хувь | 38 өвчтний хавьтал 89 хүний 69 хүнийг эмчилгээнд хамруулсан. | 30% | Далд халдварын сүрьеэгээр нийт 112 хүн бүртгэгдэж эмчлэгдсэн байна. Үр дүн: Хавьтал 100% далд халдварын эмчилгээнд хамрагдсан. | 100% |
| 3.1.3 | Сүрьеэ өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа, өдөрлөг, аян зохион байгуулна | - | -Зохион байгуулсан үйл ажиллагаа<br>-Хамрагдсан иргэд | Хурал-1, өдөрлөг-1, сургалт-3 удаа, нийт 3323 хүн | 3500 | Сүрьеэгийн өвчнөөс урьдчилан сэргийлье ажлын байрны сургалтад 9 аж ахуй нэгж байгууллага, 4 сургуулийн 1324 ажилтан, сурагчид хамрагдсан.<br><br>• Монгол- Оюу, Од, 4-р сургууль, Дархан дээд, Политехникийн коллежи, Оюуны ирээдүй цогцолбор, 15 Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ба дунд ангиудын 262 сурагчид, СӨББ болон ЕБС-н 46 эмч | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдсан. | | мэргэжилтнүүд оролцуулсан мэдлэг батжуулах зорилгоор АХА, Алтан хонх тэмцээнийг зохион байгуулсан.<br>• Сүрьеэгийн халдвараас сэргийлье Эмчийн зөвлөгөө нэвтрүүлэг-1 удаа, DBS, RGB телевизүүдээр Монгол улс, Дархан-Уул аймгийн сүүлийн 5 жилийн өвчлөлийн байдал, Сүрьеэ өвчний тухай ойлголт, Дархлаа дэмжих, Төр болон ТББ-н хамтын ажиллагаа, сүрьеэгээс халдвараас сэргийлэх талаар иргэдэд сүрьеэгийн халдвараас сэргийлэх мэдээлэл 2 удаа тус тус өгсөн.<br>Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр Эрүүл мэндийн байгууллагууд, Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг хамтран нус цэрээ ил задгай хаяхгүй байх, зөв ханиаж найтаах Дархан зах, Их дэлгүүр, Олон улсын худалдааны төв, Номин худалдааны төв, Үйлчилгээний төв зэрэг томоохон худалдааны газруудын түрээслэгч нар, үйлчлүүлэгч нарт чиглэсэн Эрүүл мэндийн байгууллагууд хуваарилагдсан газарт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 2800 гаруй иргэдэд мэдээлэл өгч, зөвлөмж тарааж ажилласан. | |
| **Зорилт 4. Бэлгийн замаар дамжих халдвар хүний дархлал хомсдлын вирусын халдвараас сэргийлэх, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх, иргэн төвтэй эрүүл мэндийн цогц чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж халдварын тархалтыг бууруулах** | | | | | | | |
| 4.1.1 | ХДХВ, тэмбүүгийн тархалтын тандалт судалгаа хийж, зорилтот бүлгийн иргэдэд эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. | 3 сая | Тандалт, судалгааны дүн -үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн иргэд | -Тандалтад ЭБҮ, ЭБЭ 187 хүн<br>-Жирэмсэн 1604 эмэгтэйг БЗДХ/ХДХВ/ДОХ илрүүлэх үзлэгт | Үзлэг, шинжилгээ эндхамрагдалт 100% хүргэх | ХӨСҮТ-ийн БЗДХ,ХДХВ/ДОХ-ын тандалт судалгааны албанд БЗДХ,ХДХВ/ДОХ-ын нууцлал, хамгаалалт бүхий ажиллагааны бүртгэл мэдээллийг сар бүр мэдээлж ажиллаж байна. Жирэмсний хяналтанд шинээр орсон нийт 1541 жирэмсэн эмэгтэйд Зонхилон тохиолдох БЗДХ/ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээг хийхэд нийт бүртгэгдсэн өвчлөл 188. БЗДХ-ын 37 шинэ тохиолдлын 19.6%-ийг жирэмсэн эмэгтэйчүүдийн өвчлөл эзэлж байна. 100% хяналтад авч эмчилсэн ба төрөлхийн тэмбгг гаргаагүй ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Хөдөлгөөнт хүн ам болон эрсдэл бүлэгт чиглэсэн БЗДХ,ХДХВ,ДОХ-оос сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | 1 сая | Зохион байгуулсан нөлөөллийн үйл ажиллагаа | Сургалт-54 удаа, 1964 хамрагдсан. | 2000 | Эрсдэлт бүлгийн хүн ам болох Орон гэргүй тэнэмэл, иргэдэд үзлэг хийж зөвөлгөө өгсөн. ЭБЭ-124, ЭБҮ-24, Хөдөлгөөнт хүн ам-2110, ШШГГ ангийн хоригдол-161, БЗДХ-ын кабинетын үйлчлүүлэгчид-165 нийт 589 эрсдэлт бүлэгт чиглэсэн ХДХВ-ийн халдвараас сэргийлэх ухуулга, сургалт, сурталчилгаа хийсэн байна. | 100% |
| **ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Эмнэлгийн анхан болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, багцын стандартыг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах** | | | | | | | |
| 2.1.1 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллана. | - | Өрхийн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээний хувь | Өрхийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 94.2%, 1-4 улирал ХШҮ ӨЭМТ:88.6% | Дундаж үнэлгээ 90% | “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам" батлагдсан ба ЭМС-ын А/122, А/320,А/321 тоот тушаал гарсантай холбогдуулан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шинэчилсэн тушаалыг танилцуулах сургалтыг 68 ажилтанд зохион байгуулсан. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллана байна. 1-улирлын үнэлгээгээр 84.9%, 2-улирлын үнэлгээгээр 87.6%, 3-улирлын үнэлгээгээр 80% тус тус үнэлэгдсэн 15 төрлийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилт 90,2%-тай, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2024 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт: ГОСХОТ ӨЭМТ 99.1%, Аминхолбоо ӨЭМТ 99.3%, Гэрэлтэй ӨЭМТ 86.1%, МЭДСТОП ӨЭМТ 93.7%, Түвшинхолбоо ӨЭМТ 93.0% байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүд хагас жилийн байдлаар ***‘’ХАНГАЛТАЙ’’*** үнэлгээ авсан байна. 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс жилийн эцсийн гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг дүгнэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Алслагдсан бүс нутаг дахь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор багийн эмч нарыг автомашинаар хангаан тусламж үйлчилгээ үзүүлнэ. | - | Тусламж үйлчилгээ авсан хүний тоо | 1215 | 1500 | Монгол улсын нийт нутгаар өвөлжилт, хаваржи хүндэрсэнтэй холбоотой 2024 оны 02 дугаар сарын 20- өдрийн 5/625<br>тоот, Эрүүл мэндийн сайдын 02 дугаар сарын 19-ны өдри А/69 “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх туха тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2024/02/2 ын өдрийн<br>А/15 тушаалаар түр журмыг үндэслэн эрүүл менди тусламж, үйлчилгээг зохион байгуулж, хүн, эмийн нөө тоног төхөөрөмж, оношлуур, хамгаалах хувцас хэрэглү автомашины бэлэн байдал хангаж ажиллсан. Өрх сум эрүүл мэндийн төвүүд тус тушаал шийдвэрт холбоотойгоор Явуулын үзлэгийг эрчимжүүлж. Алслагдс хүнд амьд явуулын үзлэг зохион байгуулж нийт 1699 өрхи 3950 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүл ажилласан. Шарын гол СЭМТ 2 автомашин,, Хонгор СЭМ 2 автомашинаар хангагдсан. | 100 |
| 2.1.3 | Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана. | - | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 952 | Тохиолдлын тоогоор ЭТҮ-г хүргэх | Дархан-Уул аймагт харьялаллын бус нийт 5744 иргэн тусламж үйлчилгээ авснаас 3089 иргэн эмнэлэгт хэвтсэн. 2655 иргэн амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 100 |
| 2.1.4 | “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг"-т хүн амыг хамруулах үйл ажиллагааг идэвхижүүлж, албан хаагчдыг хамруулахад ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг хангаан ажиллана. | - | -Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, хувь | 0-17 нас 80.3% 18-аас дээш насны иргэд 24.05% | -Иргэдийн хамрагдалтыг 70 хувьд хүргэх | Хүн амын дунд “Эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо”-г идэвхжүүлэх, зохион байгуулахад ЭТҮХ-ийн мэргэжилтнүүд сар тутмын мэдээ, тайланд дүгнэлт хийж эрчимжүүлэх чиглэлийн дэмжлэгт хяналтыг 6 удаа эрүүл мэндийн байгууллагад хийж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 64757 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 48.5% эзэлж байна.<br>0-17 нас хамрагдвал зохих хүн ам **37382, х**амрагдсан хүн ам **32405** буюу **86.6%**, 18-с дээш нас 65857 хамрагдахаас 23426 хамрагдаж 35.5%-тай байна. Нийт хамралт дунджаар **61.05%** (48.4% улс) буюу 12.6%-иар өндөр байна. Энэ нь улсын дунджаас/ 3.5%-иар өндөр байна. Эрт илрүүлэг үзлэгийн нөхцөл байдлын талаарх 21 удаагийн мэдээллийг бэлтгэн аймгийн Мэдээлэл | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | технолгийн алба болон DBS, RGB телевиз, ЦЭЦ.МН сайт, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэсэн.<br><br>Мөн орон нутгийн Дархан телевиз /DBS/ Эрүүл мэндийн цаг нэвтрүүлгийн 8 удаагийн дугаарт Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ,оношилгооны нөхцөл байдал, урьдчилан сэргийлэлтийн мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэн ажиллаж байна. Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн эрт илрүүлэх үзлэгийн баг Шарын гол, Хонгор сумын ЭМТ-д, Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн баг Дархан суманд ажиллахад иргэдийн оролцоог ханган үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.<br><br>“Зүрх мартахгүй төсөл”-ийн хүрээнд Сонгдо эмнэлгийн захирал, Монгол улсын гавьяат эмч Б. Болдсайхан болон зүрх судасны их эмч нар , Мёнжин эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын багийн хамтарсан үзлэгийг зохион байгуулсан. | |
| 2.1.5 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын үйл ажиллагааг идэвхижүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн бэлдэхэд дэмжиж ажиллана. | - | Цус цусан бүтээгдэх үүн | 878 нэгж цус, сийвэн бэлтгэсэн | 878 нэгжээс доошгүй бэлтгэх | Суурин хэлбэрээр бүхэл цусны цуглуулалт 859 нэгж, явуулын цус цуглуулалтаар 138 нэгж цус цуглуулсан. Аферезийн аппаратаар сийвэнгийн цуглуулалт 15 донороос 39 нэгж сийвэн цуглуулсан. Цусны салбар төв нь 8 нэр төрлийн 482 цувралын 2171 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.<br>Захиалгаар Ялтаст эсийн өтгөрүүлэг 30 нэгж, эмгэг нярайн тасгийн захиалгаар цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн өтгөрүүлэг 13 нэгж, улаан эсийн өтгөрүүлэг 37 нэгжийг үйлдвэрлэсэн.<br>ЦССҮТ-с В бүлгийн сөрөг даршилсан улаан эс 4 нэгжийг тээвэрлэж сэлбэсэн байна. | 100 |
| **Зорилт 2.2. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг бууруулах** | | | | | | | |
| 2.2.1 | Өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хамрагдалтыг | - | Хамрагдс ан хүний тоо | 1341 иргэнд хамрагдс ан. | 1350 | Өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хамрагдалтыг нэмэгдүүлж. Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г нэмэгдүүлж ажиллаж байна. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | | | | | - Үзлэг 1321 иргэн<br>- ЭХО, ЭКГ 115<br>- Нярайн шарлалт хэмжих 58 | |
| 2.2.2 | Анхан шатны тусламж үйлчилгээнд МонПЭН, Халдварт бус өвчин, зүрх судасны өвчнөөс сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож ажиллана. | 500.000 | Хамрагдсан хүний тоо, хувь | 70.7% | 72% | Анхан шатны тусламж үйлчилгээнд МонПЭН, Халдварт бус өвчин, зүрх судасны өвчнөөс сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож ажиллана. 2024 оны 11 сарын 30 ны байдлаар Монпэн-гийн үзлэгт 3 Өрх 5 сум хамрагдвал зохих 65859 үүнээс хамрагдсан 41869 /63.5%/ иргэн хамрагдсанаас Артерийн даралт ихсэлт 485 /1.1%/ Зүрх судасны өвчлөл 186/0.4%/ чихрийн шижин 78/0.1%/ тус тус оношлогдож хяналтан авч зөвлөгөө өгч ажилласан байна. | 88.1 |
| 2.2.3 | Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлтийг сайжруулан, тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулна | | Үзлэгийн хувь | 30% | 30% | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/41 тоот тушаал “Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, ЭМС-ын А/71 тоот тушаал “Томуугийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний заавар” журмын дагуу Томуугийн “АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТ”-ийн үед зорилтот бүлгийн иргэдэд гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>Сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэг 47092 үүнээс гэрийн эргэлт 8149 буюу 17.3% эзэлж байна. Үүнд: Шарын гол-16% , Орхон-18.5 %, Хонгор-19.5%<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт үзлэг 260523 үүнээс гэрийн эргэлт 82260 буюу 31.6% эзэлж байна. | 81.5 |
| **Зорилт 2.3. Эмнэлгийн тусламж үйчилгээнд оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулах ажиллагааг зохион байгуулна.** | | | | | | | |
| 2.3.1 | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.3.4 дэх заалтын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулахад дэмжиж ажиллана. | 20 сая | шинэ технологи | 4 шинэ технологи | шинэ технологи 2-4 | Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг нь ОХУ-ын Улан-Үд хотын Семашкогийн нэрэмжит улсын эмнэлэгт “Бүлэн уусгах эмчилгээ”-ний чиглэлээр туршлага судалж бүлэн хайлуулах эмчилгээг орон нутагтаа нутагшуулан ажиллаж байгаа бөгөөд тархины шигдээс оноштой 2 тохиолдолд эмчилгээг амжилттай хийсэн байна. Үр дүн 100%. Нэг удаагийн эмчилгээний өртөг 11 сая төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | MОН/007 төслийн хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүрх судасны эмч нарийн баг Дархан-Уул аймгийн эмч нартай хамтран Өнгөц венийн судасны бүлэнт бөглөрөл оноштой 5 иргэнд мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мэс заслын тасгийн их эмч Б.Ариунболд энэхүү мэс заслыг орон нутагтаа нутагшуулахаар хамтран ажиллаж байна.<br>Уушиг тайрах хагалгааг ХӨСҮТ-ийн багтай хамтран 2 үйлчлүүлэгчид, Умайн гадуурх жирэмслэлтийн дурангийн хагалгаа 1, Фимоз оноштой хүүхдэд лазер мэс засал, Ухархайн нулимсны хүүдий залгах хагалгааг (DCR)1 өвчтөнд тус тус хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгээр Турк улсын хог хаягдал ариутган, бутлах Автоклавын суурилуулсан. | |
| 2.3.2 | Жаргалан эмэгтэйчүүдийн үзлэгийн төв байгуулж, эмэгтэйчүүдэд тусламж үйлчилгээг чирэгдэлгүй цогц байдлаар үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана. | 40 сая | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 6000 | тохиолдлын тоогоор | Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын даргын санаачлагаар Эрүүл мэндийн газрын нэг давхарт “Жаргалтай ээжүүд” нэг цэгийн төвийг байгуулан 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус төв нь Дархан сумын 1-18 дугаар багийн жирэмсэн эхчүүд, Хонгор, Орхон, Шарын гол сумын жирэмсэн эхчүүдэд ШЕШ,ЦЕШ, мазок, жирэмсний эхо, ургийн зүрхний цахилгаан бичлэг, эх барих болон эмэгтэйчүүдийн эмч нарын ерөнхий үзлэг зэрэг тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>Жаргалтай ээжүүд төвд үзлэгийн 3 их эмч, жирэмсний эхо 1 их эмч, эх баригч 3 ажиллаж 1656 эмэгтэйчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Иргэдийн сэтгэл ханамж 100%, тав тухтай орчин бий болгон, нэг цэгт төвлөрүүлснээр жирэмсний тусламж үйлчилгээний чирэгдэл буурсан. | 100 |
| 2.3.3 | Ангиографийн тоног төхөөрөмжөөр хангаж, хүний нөөцийг чадавхижуулан, эрүүл мэндийн тусламж | 50 сая | Тусламж үйлчилгээ авсан | - | тохиолдлын тоогоор | Улсын төсвийн 4.2 тэрбум төгрөгний санхүүжилтээр Дархан-Уул аймагт ангиографийн аппарат суурилуулагдах төсөв хөрөнгө шийдэгдсэн ба тендер зарлагдсан. Зүрхний ангиаграфийн чиглэлээр 1 их эмчийг сургаж байгаа бөгөөд тоног төхөөрөмжтэй | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | | иргэдийн тоо | | | ажиллах техникч, сувилагч, инженер зэрэг мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад хамруулж байна. Судсан доторх оношилгоо эмчилгээг нэвтрүүлэхээр гэмтлийн тасгийн 4 палатыг шинэчлэн засварлаж ангиографийн аппарат суурилуулах төлөвлөлтийг хийсэн. | |
| 2.3.4 | Диабетын нэгж байгуулж тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хяналтын иргэдийн нэгдсэн бүртгэлийн сантай болно. | - | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 816 | тохиолдлын тоогоор | -ЭМЯ болон Орбис ОУБ-ын чихрийн шижингийн төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлгийн амбулатори-1 тасагт Диабетийн төв байгуулахаар өрөө тасалгааны тохижилт хийсэн. Дотоод шүүрлийн их эмч 1, дотоод шүүрлийн сургагч багш, сувилагч 1 ажиллаж байна.<br>“Чихрийн шижин болон чихрийн шижингийн шалтгаант ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох” төслийн хүрээнд чихрийн шижинтэй үйлчлүүлэгчдийг бүртгэлжүүлэх зорилгоор 710 үйлчлүүлэгчийг бүртгэн, төрөөс үнэгүй болон хөнгөлөлттэй эмийг эмчийн заавраар олгоэ байна.<br>.Мөн Нэгдсэн Эмнэлэгийн 439 эмч, эрүүл мэндийн ажилтныг Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт хамруулан эрсдэлтэй 147 ажилтанд шинжилгээ хийж, эмчилгээнд хамруулсан. | 90 |
| **Зорилт 2.4. Жирэмсэн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |
| 2.4.1 | Жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний үр дүнг тооцож, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана. | - | -Хамрагдсан иргэдийн тоо<br>-Эрүүлжилтийн хувь | 1672 жирэмснэс БЗДХ илэрсэн 64 эх, хавьтагчийн хамт эмчлэн эрүүлжилт 100% | Жирэмсэн эмэгтэйг 100% шинжилгээнд хамруулж, Эрүүлжилт 100% | Жирэмсний хяналтад шинээр 1656 эмэгтэй хяналтад орсоноос эхний 3 сартай 1604 буюу 96.86%-тай байна. Жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг үзлэг шинжилгээнд 1656 эмэгтэй хамрагдсанаас трихомониаз 30, тэмбүү 20, заг хүйтэн 1 илэрсэнг 100% хавьтагчийн хамт эмчлэн эрүүлжүүлсэн. | 100 |
| 2.4.2 | Жирэмсний эрт үеийн хяналт, хамралтыг сайжруулахад | - | Эрт хамралтын хувь | 1672 эмэгтэй хамрагдсаны 1619 | 95% дээш | 2024 оны 10 сарын 30-ны байдлаар 1656 жирэмсэн эх хянагдаж байна. Жирэмсний эрт үеийн хяналт, хамрагдалтыг сайжруулах зорилгоор өрх, сумын ЭМТ- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил арга зүйгээр ханган ажиллана. | | | буюу 96.8% эрт хяналтад орсон. | | ийн дарга, эх баригч нар, Нэгдсэн эмнэлгийн амаржих тасгийн эмч мэргэжилтэн, ЭЗӨ кабинет, Жаргалан төвийн эмч нарын хамтарсан зөвлөгөөн хэлэлцүүлэг зохион байгуулан эхчүүдийн эрт үеийн хяналт,тусламж үйлчилгээг сайжруулах, хүндрэлээс урьдчилан сэргийлэх зөвөлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилт 90.3% байна. “Жаргалтай ээжүүд” нэг цэгийн төвийг байгуулан жирэмсэн эхчүүд болон эмэгтэйчүүдэд 1 дороос тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн. | |
| 2.4.3 | Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд “Гарц” арга хэмжээг хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган, гүйцэтгэлд хяналт тавин ажиллана. | 1 сая | - Хамрагдсан хүний тоо, хувь – Эрүүлжилт | Хамрагдвал зохих 930-аас 806 буюу 86.6% Эрүүлжилт 75.6% | - Хамрагдалтыг 90% хүргэх Эрүүлжилт 76% | Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.1.5. Хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн тусламж үзүүлдэг 9 эмнэлэгтэй хамтран “Гарц” арга хэмжээг зохион байгуулна гэж заасан байдаг. Энэ хүрээнд Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн 5 их эмч, Хувийн эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 9 эмнэлгийн захирал, өрх сумын ЭМТ-ийн 9 эх баригч, эмч нарт УБ хотын Юнимед эмнэлэгтэй хамтран Юнимед эмнэлгийн Үр шилжүүлэн суулгах төвийн захирал АУ-ны Доктор, дэд профессор Р.Хадбаатар эмч, Юнимед эмнэлэг Эмэгтэйчүүд, үргүйдлийн их эмч Ч.Хулан нар сургалт явуулж, үргүйдлийн шалтгаантай 4 эмэгтэйг үзэж, зөвлөгөө өгсөн ба өрх, сумын ЭМТ-ийн эмч, эх баригч нарт үйлчлүүлэгчийг хэрхэн оношлох, юун дээр анхаарах, хэрхэн зөв чиглүүлэх тал дээр зөвлөгөө өгч дадлага хийсэн. “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ ЭМС-ын А/760 дугаар тушаалыг танилцуулсан. Гарц арга хэмжээний хүрээнд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулж, тусгай зөвшөөрөл бүхий эмэгтэйчүүдийн хувийн эмнэлгийн захирал нартаа Гарц арга хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан.<br><br>Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн “ГАРЦ” арга хэмжээний үзлэгт хамрагдвал зохих 328-аас хамрагдсан 324 буюу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 98% байна. Үүнээс 54 өвчлөл илэрснийг 77.6% эмчлэн эрүүлжүүлсэн. Миом 3 илрүүлж диспансерын хяналтанд авсан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг жирэмслэлтээс сэргийлэх гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслээр нийт 113 эмэгтэйд үйлчилсэн байна . Үүнд: бэлгэвч 16 хүн 20 ш, тариа 23 хүн, ерөндөг 21хүн , жирэмснээс хамгаалах эм 33 хүнд өгч үйлчилсэн байна. | |
| 2.4.4 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлт, жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулахад мэргэжил арга зүйгээр хангаж үр дүнг тооцож ажиллана. | 10 сая | - Хамрагдсан тоо, төрөл | тариа 1280, суулгац 160, даврын эм 2646, бэлгэвч 6190, ерөндөг 600 ш | ЖСА хэрэгслэлийн хангалтыг 60% хүргэнэ | 2024 оны тендэр худалдан авалтаар 21,06,1500 төгрөгний жирэмснээс сэргийлэх эм тарианы худалдан авалт хийгдсэн байна. Үүнээс: Гос хот 6.259.500 төг, Аминхолбоо 816.000 төг, Гэрэлтэй 1.816.000 төг, Мэдстоб 3800000 төг, Шарын гол 1.483.500 төг, Хонгор 5.047.500 төг Жирэмснээс сэргийлэх эм, тарианы захиалга хийж авсан байна.<br><br>2024 оны Жирэмснээс сэргийлэх тариа 640ш, суулгац 160 ш, даврын эм 1735 ш, бэлгэвч 6240ш , ерөндөг 500 ш, жирэмсний тест 650 ш хангагдан зорилтот нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 60.2%-ийг ЖСА-д хамруулсан байна. | 100 |
| 2.4.5 | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиоддолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ. | - | Тохиолдлын тоо | - | - | Тохиолдол гараагүй | 100 |
| **Зорилт 2.5. Хүүхэд, нярайн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, бага насны хүүхдийн суурь өвчин, гүйлсэн булчирхайн эмгэгийг эмчлэх тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.1 | Нярайн скрининг (түнх, зулай ЭХО, нярайн сонсголын скрининг) үзлэгийн чанар үр дүнг сайжруулахад мэргэжил арга зүйгээр ханган үр дүнг тооцож ажиллана. | - | -Нярайн скрининг хамрагдсан хүүхдийн үр дүн, хувь | Түнхний ЭХО 1840, Зулай 32, Сонсголын скрининг 136-д нярайд хийсэн | Төрсөн нярайд скрининг үзлэг 100% хийх | Нярайн скрининг үзлэгийг нийт 1669 төрсөн нярайд хийсэн.<br>- түнхний скрининг 1669<br>- нярайн зулайн ЭХО 69,<br>- сонсголын скрининг 11<br>- зүрхний гажиг эрт илрүүлэх скрининг 615 нярайг хамруулсан.<br>Түнхний ЭХО үзлэгт хамрагдсан 1669 нярайгаас type A- 1620, typeB- 45, typeC- 4, давтан- 51, эдгэрсэн- 42. Зүрхний гажгийг эрт илрүүлэх скрининг оношилгоог нэвтрүүлж нийт 615 нярайг оношилгоонд хамруулж эрсдэлтэй 1 нярайг дээд шатлалын эмнэлэгт үзүүлэх зөвөлгөө өгсөн. Фото эмчилгээнд орсон нярай 1233. Шинээр нүдний скрининг оношилгоог хийж эхэлсэн бөгөөд нийт төрсөн нярайг хамруулж, оношлогдсон 1 нярайг нүдний эмчийн хяналтад авсан. | 100 |
| 2.5.2 | 9, 18, 36 сартай хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | - Хамрагдсан хүүхдийн тоо Эрүүлжүүлсэн хүүхдийн тоо | -18 сартай үзлэгт 1234 хүүхэд Эрүүлжилт 90% -36 сартай 1298 хүүхэд | Тохиолдлын тоогоор | ЭМГ даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/107 тушаалаар батлагдсан “Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах” ажлыг зохион байгуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>9,18,36 сартай хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдвал зохих 4562 хүүхдээс 4300 хүүхэд буюу 94.2%-тай хамрагдсан.<br>Үзлэгээс нийт илэрсэн өвчлөл 721 ба эрүүлжилт 526 буюу 73% -тай байна.<br>Анеми 123, Рахит 264 ,шүдний өвчин 335, Харшил 10, Хөгжлийн хоцрогдолтой 8 хүүхэд илэрсэнг ЭХЭМҮТ-д илгээж, эмчийн хяналтад авч эмчлэн эрүүлжүүлсэн.<br>9, 18, 36 сартай хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх арга зүйн сургалтыг 5 өрх, 3 сумын эмч мэргэжилтэн 52 хүнд эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн шинэчилсэн хувилбарыг ашиглах, бага насны хүүхдийн хөгжлийн үнэлгээ сэдэвт сургалтыг зохион байгуулсан. | 90 |
| 2.5.3 | Шинэчилсэн ХӨЦМ болон олон нийтэд суурилсан ХӨЦМ-ийн сургалт зохион байгуулна. | - | сургалтанд хамрагдсан эмч | -Сургалт 1786 эцэг,эхчүүдэд -285 эмч мэргэжил | 1500 эцэг эх эмч мэргэжилтэн-80 | “Хүүхдийн өвчний цогц менежмент”-ийн тусламж үйлчилгээний талаар ЭМГ-аас “Нялх бага үеийн хооллолт, асаргаа сувилгаа” арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг сургууль, цэцэрлэгийн эмч нарт 2 удаа зохион байгуулж нийт 28 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Хүүхдийг эрэмбэлэн ангилах яаралтай тусламжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тусгай мэргэжилтнүүдийн тоо - сургалтанд хамрагдсан эцэг эхчүүдийн тоо | тэн хамрагдсан. | | мэдлэг чадварыг сайжруулах ажлын байрны дадлага сургалтыг 5 өрх, 3 сумын 285 эмч мэргэжилтэнд 15 удаа зохион байгуулсан. Сургалтын өмнөх сорил 40% байсан ба сургалтын дараа 91% болсон. Дадлага хичээлийг нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт хийсэн.<br>"Хүүхдийн өвчний цогц менежмент" сэдвээр ӨЭМТөвөөр үйлчлүүлж байгаа 1598 иргэдэд сургалт мэдээлэл хийж 4 төрлийн зөвлөмжийг 2000 ширхэг тараасан байна.<br>ХӨЦМ-ийн хяналт үнэлгээг өрх, сум, НЭ-ийн хүүхдийн тасагт 2 удаа зохион байгуулсан. Үнэлгээг 91%-тай байна. Эх хүүхдийн дэвтрийн хэрэглээ, МОРБИС үнэлгээний дундаж 81%-тай байна.<br>Олон нийтэд түшиглэсэн нялх балчир насны хүүхдийн хооллолтын дэмжлэгт хяналтыг 2024 оны 11 дүгээр сарын 6-наас 11 дүгээр сарын 20-ны өдрийг хооронд 5 өрх, 3 сумын ЭМТөвүүдэд хийж, үнгэлгээнд 48 хүн хамрагдсан ба дундаж үнэлгээ 78% байна. | |
| 2.5.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах эмчилгээнд хамруулах, тэдний эцэг асран хамгаалагчдыг асаргаа сувилгаа хийх сургалтад хамруулна. | 1 сая | - Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | 318 | 320 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах кабинетаар 187 хүүхдэд сэргээн засах тусламж үзүүлсэн. Үүнд:<br>- Саажилттай --45<br>- Гилжгий-21<br>- Өсөлт хөгжилтийн хоцрогдол-23<br>- Толгойн бариа--22<br>- Майга тавхай-2<br>- Цэр суллах доргионт массаж--20<br>- Хүчилтөрөгчийн дутмагшил-33<br>- булчингын чангарал-21<br>-Зөөлөн тосон бариа-187 хийсэн ба эмчилгээний үр дүн 84.5% байна.<br>Эцэг эх асран хамгаалагч 58 хүнд гарын доорхи материал ашиглан гарын чиг , хөлийн чиг хийх арга аргачлал, зөв хэвтүүлэх суулгах булчин суллах дасгал хийх аргачлалыг зааж өгсөн. ХБХ-ийн эцэг эхчүүдэд**'' Тэд чадна Бид дэмжинэ''**дадлагажих сургалт зохион байгуулсан. Сургалтанд 50 эцэг эх хамрагдсан.ХБХийн зөв хоололт, шүд угаах арга, гэрийн асаргаа сувилгаа, гэрийн нөхцөлд дасгал хөдөлгөөн хэрхэн хийх вэ зэрэг цуврал сургалтуудыг 8 удаа зохион байгуулж 152 эцэг эх, асран хамгаалагч нар хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн кабинетаар үйлчлүүсэн 45 хүүхдийн эцэг, эхэд ХӨЦМ-ийн хүүхдийн аюултай ерөнхий шинж, амьсгал тоолох, ханиадыг хоргүй зөөлөн эмээр эмчлэх, олон найрлагат бичил тэжээлийн хэрэглээ, Вит А, Вит Д хэрэглэх заавар зөвлөмж, дархлаажуулалтын ач холбогдол сэдвээр зөвөлгөө зөвлөмж өгч ажилласан. | |
| 2.5.5 | Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, үр дүнг тооцон ажиллана. | 2 сая | Зохион байгуулсан үйл ажиллагаа | - | - | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 сарын 06-ны өдрийн А/263 дугаарын тушаалын дагуу Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдлийг магадлан хэлэлцэх хурлыг 3 удаа зохион байгуулж, I улиралд 3 тохиолдол, II улиралд 4 тохиолдол, III улиралд 3 тохиолдол нийт 10 тохиолдлыг авч хэлэлцэн НЭ-т 6 төрлийн зөвлөмж, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд 4 төрлийн зөвлөмж өгч ажиллан зөвлөмжийн хэрэгжилт 83%-тай байна. | 90 |
| **Зорилт 2.6. Олон улсад хүлээн зөвшөөрсөн эмнэлзүйн заавар, стандартад суурилсан, оношилгоо, эмчилгээг нэвтрүүлэх** | | | | | | | |
| 2.6.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | 1 сая | - Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br>-Хяналт зөвлөмж | 50 | 100 | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг төлөвшүүлэх аяныг 2024.01.15-аас 2024.12.01-ны өдрийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Стандартын сургалтыг ЭМБ-уудын 580 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудад зохион байгуулсан. Сургалтын өмнөх мэдлэг 62% сургалтын дараах мэдлэг 89% буюу 27% ахисан үзүүлэлттэй байна. Нэгдсэн эмнэлэг тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "АЖИЛТАН БҮР ХӨТӨЧ" стандартыг хэрэгжүүлэгч хамт олон сэдэвт аян зарлаж, 3 тасаг 8 алба аянд нэгдэж оролцсон байна.<br>Аминхолбоо ӨЭМТ MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024.06.14-ны өдөр иргэд үйлчлүүлэгчид рүү чиглэсэн өдөрлөгийг зохион байгууллаа. | 100 |
| 2.6.2 | Яаралтай тусламжийн нэгжийг бэхжүүлж тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийж, тусламж үйлчилгээг сайжруулна. | 50 сая. | Шаардлага хангасан автомашин, тоног | 2 төрлийн тоног төхөөрөмж, автомашин 1 | Тоног төхөөрөмж 2-3 төрөл, Автомашин 1 | .Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасагт байсан 4 ширхэг зөөврийн амьсгалын аппаратны 1 аппаратыг Яаралтай түргэн тусламжийн тасгийн 1 машинд суурьлуулсан.<br>ЭМЯ төсвийн санхүүжилтээр хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат-1 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төхөөрөм жөөр хангасан байх | | нэмэгдүүлэх | Шарын гол суманд БНСУ-ын Кёнги аймгаас иж бүрэн тоноглолтой эмнэлгийн зориулалттай автомашин 1 ш хандиваар олгосон ба үнэлгээ хийлгэж 55.0 сая төгрөгөөр үнэлэгдсэн. Шарын гол СЭМТ-д ЭМЯ-наас 1 дуудлагын аютомашин. УТХО-аар 4 өрхийн эрүүл мэндийн төвд суудлын автомашин, ЭМГ-т УТХО-аар 1 суудлын автомашин, Нэгдсэн эмнэлэгт УТХО-оор 2 автомашин, Гос хот ӨЭМТ өөрийн хөрөнгөөр 1 автомашин, Хонгор СЭМТ ОНХС-аас 1, УТХО-аар 1 автомашинаар тус тус хангагдсан байна. | |
| 2.6.3 | Зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна. | - | Сурталчилгаанд хамрагдсан хүний тоо | 3 удаа 852 иргэд | 850 иргэн | Эрт илрүүлэг үзлэгийн нөхцөл байдлын талаарх 21 удаагийн мэдээллийг бэлтгэн Дархан-Уул аймгийн Мэдээлэл технолгийн алба болон DBS, RGB телевиз, ЦЭЦ.МН сайт Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэсэн.<br>Мөн орон нутгийн Дархан телевиз /DBS/ Эрүүл мэндийн цаг нэвтрүүлгийн 8 удаагийн дугаарт Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгооны нөхцөл байдал, урьдчилан сэргийлэлтийн мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэсэн.Хандалт 872 | 100 |
| 2.6.4 | Симуляци сургалтын төвд эмч, эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдлийг чадавхижуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үйл ажиллагааг идэвхижүүлнэ. | - | Сургалтад хамрагдсан ЭМА тоо | 265 | 300 | Нярайн тасгаас санаачилан зохион байгуулсан Монголын Перинатологи нийгэмлэг, Millinnium RDS, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар сургууль хамтран төвийн бүсийн чуулган-2024 “Нярайд амьдрал бэлэглэе” сэдэвт VIII алгоритмын ур чадварын 3 хоног сургалтыг зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтнүүдийн "Амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эмнэлэг дэх гэнэтийн амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэх зорилго бүхий “ЦЭНХЭР КОДООР ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХЭД БИДНИЙ ОРОЛЦОО” сэдэвт мэргэжлийн ур чадварын дадлага сургуулилтын тэмцээнд зрхион байгуулж Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын 80 гаруй эмч мэргэжилтэн хамрагдсан байна. Сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн гардан ур чадварыг нэмэгдүүлэх сургалт 12 удаа зохион байгуулж 297 эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. | 100 |
| **Зорилт 2.7. Уламжлалт анагаах ухаан, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7.1 | Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, хүний нөөцийг чадавхижуулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана . | - | - Сургалтад хамрагдсан ажилтны тоо -Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | Хэлэлцүүлэг-1 удаа Сургалтад 51 эмч мэргэжилтэн -Өдрийн эмчилгээнд 177, хэвтэн эмчлүүлсэн 753 иргэн | Сургалтад хамрагдах ажилтан 15 -Тусламж үйлчилгээ шаардлагатай иргэд | УАУ-ны дотор судлалаар 1 их эмч, , бакалаврын онлайн сургалтад 6 сувилагч суралцаж байна. 2 сувилагч сэргээн засах эмчилгээний сувилахуйн олгох сургалтад хамрагдсан. Мэдрэлийн зонхилон тохиолдох эмгэгийн УАУ-ны оношилгоо, эмчилгээ сургалтад 23 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br><br>"Уламжлалт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй ахмад настны өвчлөлийн байдлыг судлах нь" сэдвээр тасгийн эмч сувилагч нар судалгаа хийж илтгэл танилцуулан эмхэтгэлд хэвлэгдсэн. Ахлах сувилагч Ц.Учрал УГТЭ "Үйлчилгээний стандартад сувилагчийн манлайлал" Х-р сургалт, семинарт илтгэл танилцуулж эмхэтгэлд хэвлэгдсэн.<br><br>Уламжлалтын тасгийн амбулаториар 1595 үйлчлүүлэгч тусламж үйлчилглээг авсан.<br>Өдрийн эмчилгээнд 151 үйлчлүүэгч үйлчлүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг 3 төрлөөр 993 хүнд үзүүлсэн байна. | 100 |
| 2.7.2 | Хөнгөвчлөх, хими эмчилгээний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | -Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо - Сургалтад хамрагдсан хүний нөөц | - Кабинетаар 2287 -Тасагт 527 тусламж үйлчилгээ авсан. - Сургалтад хамрагдсан хүний | - Тусламж үйлчилгээ авсан иргэдийн гүйцэтгэлээр - Сургалтад хамрагдах хүний нөөц 35 | Хавдар, хөнгөвчлөх кабинетаар нийт 4070 иргэн тусламж үйлчилгээ авсан байна.<br>• Амбулаторын нийт үзлэг 1793<br>• Идэвхтэй хяналт 1131<br>• Гэрийн дуудлага 18<br>• Өдрийн эмчилгээнд 25<br><br>• Хөдөлмөр зохицуулалт хийгдсэн хүний тоо- 58.<br>• Нийт хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 1405.<br>Хөнгөвчлөх эмчилгээний тасаг 8 ортой нийт 341 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн.<br>ХСҮТ, Монголын Коро Хэрт эрүүл мэнд, боловсролын нийгэмлэг, НДЕГ-аас зохион байгуулсан 6 төрлийн цахим болон танхимын сургалтад давхардсан тоогоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нөөц 30 | | хавдар, хөнгөвчлөхийн 22 эмч, сувилагч хамрагдсан. Хавдрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад удирдах ажилтануудын оролцоо, хавдрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүн амд үзүүлдэг эмч мэргэжилтнүүдийн уялдаа "Фокус ярилцлага"-ыг 20 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Хими эмчилгээний чиглэлээр:<br>• ХСҮТ-д хими эмчилгээний тасагт 2 сувилагч, 1 эмзүйчийг ажлын байранд 14 хоногийн дадлага сургалтанд хамруулсан.<br>• Хими эмчилгээг найруулах Laminar box, хими эмчилгээг найруулах өрөөний засвар хийгдэж 14 хүнд полихими эмчилгээ хийсэн байна. | |
| 2.7.3 | Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн сургалт зохион байгуулж, стандартын хэрэгжилтийг үнэлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана . | - | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо, үнэлгээний хувь | -11 удаагийн сургалт 672 сувилагч - Гардан үйлдлийн дундаж үнэлгээ 84% | - Сургалтад 500 эмнэлгийн мэргэжилтэн -Гардан үйлдлийн стандартын хэрэгжилт 87% | Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийн сургалтыг: Тарилгын аюулгүй байдал, Тарилгын автомат шахуурга, хүчил төрөгчийн аппарат, тоног төхөөрөмж дээр ажиллах заавар, Цусны бүлэг тодорхойлох арга техник, Нярайн сэхээн амьдруулалтыг багаар үзүүлэх 8-р алгоритм, Хэвтэн эмчлүүлэгчийн цээж, уушиг, зүрхийг үнэлэх арга зүй, Холголт, цооролтын үеийн асаргаа, сувилгаа, Амилуулах, лавшруулсан тусламж зэрэг 7 төрлийн сэдвээр 20 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 503 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдаж, мэдлэгийн түвшин 24% ахисан үзүүлэлттэй байна. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилтийн түвшин тогтоох үнэлгээг онол болон дадлагын өртөгөөр зохион байгуулж, нийт 200 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсанаас онол 77%, бодит үзлэгийн өртөө 86%, яаралтай тусламж 88%, тоног төхөөрөмжийн өртөө 88%, гардан үйлдлийн өртөө 87%-иар үнэлэгдэж, дундаж үнэлгээ 85.2%, өмнөх оноос 1.2-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. "Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд сувилагчийн оролцоо" ур чадварын тэмцээнд 24 сувилач, үзүүлэх сургалтанд ЭМБ-уудын 120 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн оролцсон байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7.4 | Сувилахуйн дагнасан төвийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | -Тусламж үйлчилгээ авсан хүнйи тоо | “Урам өглөө” 1461, “Итгэл” сувилахуйн төвүүд 158 хүнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна | Дагнасан төв нь 1500 хүнд үйлчилнэ | 1.Урам өглөө сувилахуйн дагнасан төв нь:<br><br>MNS 6755:2019 Сувилахуйн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын дагуу үйл ажиллагааг явуулж байна. Гэрээр 779, сувилахуйн төвөөр 1009, нийт 1788 үйлчлүүлснээс:<br><br>• Дусал тарилга 620<br>• Судас тарилга 208<br>• Булчин тарилга 224<br>• Арьсан дор тарилга 23<br>• Сорил тарилга 11<br>• Боолт 734<br>• Бариа засал 132<br>• Артерийн даралт хэмжих 215<br>• ЭМБО сургалт 379<br>• Цагаан хэрэглэл солих 6<br>• Шээлгүүр 5 хүнд тавьсан байна.<br><br>2. Итгэл сувилахуйн дагнасан төв нь 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 48 хүнд тусламж, үйлчилгээ үйлчлүүлснээс:<br>• Дусал тарилга 32<br>• Гэрийн дуудлага 31<br>• Боолт 3 хүнд хийсэн.<br>ХХҮГ-аас “Ахмад настны өдрийн үйлчилгээ” төсөлд хамрагдаж, 3.150.000 төгрөгний санхүүжилтийг 2024 оны 6 сард авч, нийт 30 хүнд 6 өдрийн турш тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Сувилахуйн дагнасан төвийн үйл ажиллагааг өргөжүүлснээр иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 100% байна. | 100% |
| 2.7.5 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо Нэмэгдсэн тоног | давхардсан тоогоор 42530 иргэнд сэргээн засах тусламж, | Тохиолдлын тоогоор | Хатгалгааны дараах Сэргээн засах эмчилгээнд 1159, Ходоодны шарх болон сөргөө өвчтэй1350, УВЧ эмчилгээнд 240, Зөгийн балтай татлага 120,хийлгэсэн үйлчлүүлэгчийн тоо- 120, хүүхдийн Сэргээн засах эмчилгээний 4 төрлийн тусламж үйлчилгээнд 2869 хүүхэд хамрагдсан байна.<br>Харвалтын дараах нөхөн сэргээх эмчилгээг 33 эмчлүүлэгчдэд хийсэн. Эдгэрэлт 80%. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төхөөрөмж | үйлчилгээг үзүүлсэн | | Ургийн буруу байрлалтай үйлчлүүлэгч 1420, хүнд зүү эмчилгээ, Төөнө эмчилгээний 650 хүнд хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br><br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаар Сэргээн засах тусламж үйлчилгээг 11 төрлөөр 5132 иргэнд үзүүлсэн. Эдгэрэлт 78.6%-тай. | |
| 2.7.6 | Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлнэ | -2 сая | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | Стационараар 8870, өдрийн эмчилгээнд 457 ахмад настанд тусламж үйлчилгээ үзүүлсэн | 8000 ахмад эмнэлгийн тусламж үзүүлэх | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор ахмад настан эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нь нийт үзлэгийн 17.1% эзэлж байна. Эмнэлэгт хэвтсэн нийт 25482 иргэнээс ахмад настан 7579 буюу 29.7% эмнэлэгт хэвтэн тусламж үйлчилгээ авсан. | 100 |
| **Зорилт 2.8. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг үзүүлэх** | | | | | | | |
| 2.8.1 | Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн магадлан итгэмжлэл бүхий чанарын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана. | 500 мян | Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт хувь | Магадланд 8 ЭМБ орж магадлан итгэмжлэлийн хугацаа 2-3 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн. Хэрэгжилт 87% | 87% | 2024 онд магадлан итгэмжлэл сунгах 7 эрүүл мэндийн байгууллагын 22 шаардлага, 14 материалыг ЭМБ-н цахим програмд мэдээлэл оруулах, илгээх сургалтыг хийж, цахим програмд оруулсан мэдээллүүдийг хянаж эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээн баталгаажуулах зэрэгт мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлсэн. 2024 онд 1 эрүүл мэндийн байгууллага цахим хэлбэрээр, 6 эрүүл мэндийн байгууллага Магадлан итгэмжлэл үнэлэх шинжээч томилогдон ажиллаж Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 сарын 09 –ны өдрийн А\95 дугаар тушаал, 2023 оны 10-р сарын 30-ны А/378 тоот тушаалаар, 7 эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэлийн хугацаа 2-3 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн. ЭМС-ын 2024 оны А/112 тушаалын 3-р хавсралт “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” баталгаажуулах, тайлагнах журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулж сургалтад 11 ЭМБ-ын 47 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 2025 онд магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдах 10 ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явцын зөвлөн туслах сургалтыг зохион байгуулж сургалтад 54 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | |
| 2.8.2 | Эрүүл мэндийн байгууллага бүрт Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавьж ажиллана. | - | Зөвлөмж хэрэгжилт | 8 байгууллагад 11 удаагийн дэмжлэгт хяналтыг хийж 8 төрлийн зөвлөмж өгч, хэрэгжилт 86% | Зөвлөмжийн хэрэгжилт 87% | ЭМС-н А/69 тушаалын дагуу 9 эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, эм эмнэлгийн хэрэгсэл, халдвар сэргийлэлт хяналтын байдалд дэмжлэгт хяналт хийж Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ-дэд 10 төрлийн зөвлөмж, СЭМТ-дэд 12 төрлийн зөвлөмж өгч, зөвлөмж хүргүүлсэн.<br>2024 онд магадлан итгэмжлэх үнэлгээнд хамрагдсан 7 ЭМБ-д өөрийн үнэлгээнд үндэслэн дэмжлэгт хяналтыг хийж зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 87.5% | 90% |
| 2.8.3 | Чанарын аян, өдөрлөг зохион байгуулж ажиллана. | 500 мян | Оролцсон иргэдийн тоо | 4 удаагийн аянд 250 эмч, мэргэжилтэн, 1247 иргэн хамрагдсан. | 1500 хамруулсан байна. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилт танилцуулах сургалтыг нийт 13 ЭМБ-н 78 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт 7 удаагийн сургалт мэдээлэл хийж арга зүйгээр хангасан.<br>“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал дэлхийн өдөр”-ийг угтан 6 сарын хугацаатай аян зохион байгуулж байна. Үүнд “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах” 1 сарын аян, “Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал” 1 сарын аян, “Үйлчлүүлэгчийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” 1 сарын аян тус тус зохион байгуулж аяны хүрээнд нийт 118 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 365 иргэд үйлчлүүлэгчид сургалт мэдээлэл хүргэсэн. 2 төрлийн тараах материалыг 335 иргэдэд тараасан байна. “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллах, үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин бүрдүүлэх” туршлага судлах өдөрлөг зохион байгуулж нийт 1500 гаруй иргэд, үйлчлүүлэгчид хамрагдсан байна. Хэвлэл мэдээллээр нийт 3 удаагийн видео мэдээлэл хүргэж хандалт 1250 байна. | 100% |
| 2.8.4 | Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчид болон эмч ажилтны сэтгэл ханамжийн судалгааг сар бүр цахимаар | 100 мян | Судалгаанд орллцсон иргэд, | Амбулторийн сэтгэл ханамж сайн | 87% | ЭМХТ-ийн 1313.mn цахим сэтгэл ханамжийн үнэлгээнд 1905 иргэн хамрагдсан байна. Амбулаторийн тусламж үйлчилгээ авсан 1540 иргэн, хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан 365 иргэн байна. Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ: | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авч үр дүнг тооцож үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. | | ажилчдын тоо<br><br>Сэтгэл ханамжийн хувь | үнэлгээг 79.37%,<br>-Хэвтэн эмчлүүлэх сайн үнэлгээг 92.1 | | маш сайн-65.6%, сайн-28.%, дунд-4.1.%, муу-2%, маш муу-0.3% үнэлэгдсэн.<br>Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан иргэдийн дундаж үнэлгээ:<br>маш сайн-80.4%, сайн-14%, дунд 5%, муу-0.6% байна.<br>Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч нарын сэтгэл ханамжийн судалгааг нийт 340 албан хаагч нараас авч үнэлсэн байна. Үүнд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ Сайн-80.4%, дунд-17%, муу-2.6%-тай гарсан байна. байна | |
| 2.8.5 | Эрсдлийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Оролцсон ажилчдын тоо | Сургалт-2 удаа, 113 эмч, ажилтан хамрагдсан. | 120 | Эрсдэлийн менежментийн чадавх сайжруулах барилга байшингийн гамшгийн эрсдлийн үнэлгээг Гос хот, Аминхолбоо ӨЭМТ-үүд өөрсдийн хөрөнгөөр, АГХОТБАЗ-д санхүүжилтээр Нэгдсэн эмнэлэг ,ЭМГ-ын барилгын хийц газар хөдлөлийн тэсвэржилтэнд эрсдэлийн үнэлгээ хийгдсэн .<br>ЭМГ-аас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулах чиглэлээр Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг цахим программд бүртгэх, мэдээлэх зэрэг танилцуулах сургалтыг нийт 14 эрүүл мэндийн байгууллагын 145 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хийж нийт 12 эрүүл мэндийн байгууллагыг eburtgel.hdr.gov.mn цахим программд бүртгэл үүсгэж баталгаажуулсан.<br>Нэгдсэн эмнэлэг нь Хүүхэд хэвтэн эмчлүүлдэг тасгуудад хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдлийн үнэлгээг 13 хүчин зүйлээр үнэлж, эрсдлийг бууруулж ажилласан.<br>ЭМС-ын 2019.12.12-ны өдрийн А/566 тоот тушаал Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах эрсдлийн үнэлгээг улирал бүр хийж хяналт тавьж ажиллаж байна.<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл чанар аюулгүй байдлын эрдсдлийн үнэлгээг 21 хүчин зүйлээр үнэлж, эрсдлийг бууруулахаар ажиллаж байна. | 100 |
| **ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн програмын хэрэгжилтийг хангаn ажиллана | - | цахим бүртгэлд хамрагдсан байдал | Багц цагийн биелэлт 100% сургалтын тоо 25 - Хамрагдсан хүний тоо-300 | Багц цагийн биелэлт 100% - Сургалтын тоо 35 - Хамрагдах хүний тоо-320 | ЭМГ нь нийт 76 хүний нөөц, бүтэц орон тоотойгоор 5 хэлтэс, 1 төв үйл ажиллагаагаа явуулж байна. ЭМГ-т ТЗ-ын 22 албан хаагч, ТҮ-19 албан хаагч, ТҮЭМ-29 албан хаагч ажиллаж байна. ТЗ-ийн албан тушаалд 4 их эмч, эрүүл мэндийн газрын сонгон шалгаруулалтаар ТҮ-гийн албан тушаал дээр 4 албан хаагчийг ажилд сонгон шалгаруулж хүний нөөцийн бүрдүүлэлт хийж ажилласан. Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр хувийн хэвшлийн болон боловсролын байгууллагын төрийн үйлчилгээний 10, хувийн хэвшлийн 156, Анагаах болон ЕБС -ын 56 сургуулийн нийт 202 байгууллагуудын эрүүл мэндийн ажилтнуудад /http://www.hdc.gov.mn /эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн программын ашиглалтын талаар удирдлага арга зүйгээр хангаж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд хяналт тавьж ажилласан. 2024 оны мэргэжлийн сургалтын багц цагийн биелэлт 100% тай. Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим програмд 70 ажилтны мэдээллийг шинэчилсэн. Төрийн сангаар суралцах их эмч, эм зүйч, тусгай мэргэжилтнүүдэд /http://www.hdc.gov.mn /эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн программын ашиглалтын талаар удирдлага арга зүйгээр хангасан. ЭМЯ-нд зохион байгуулагдсан Удирдах ажилтны зөвөлгөөнд 2, "Эмч танаараа бахархая" уулзалт зөвөлгөөнд нийт 39, ЭМГ-с зохион байгуулсан Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвөлгөөнд 99, Эмч нарын их хуралд 30 эмнэлгийн ажилтан оролцсон. | 100 |
| **Зорилт 3.2. Эрүүл мэндийн ажилтны сургалт хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана** | | | | | | | |
| 3.2.1 | Үндсэн болон төрөлжсөн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар | - | бэлтгэсэн мэргэжил тэний тоо | 13 | 15 | Эрүүл мэндийн салбарын төгсөлтийн дараах Үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилжилтээр 9 их эмч, суралцаж байна. Үүнд: Хүүхэд судлал-2, Дотор судлал-1, Мэс засал судлал-1, Эх барих эмэгтэйчүүд судлал-1, Анатомийн эмгэг судлал-1, Нүүр амны согог засал судлал-1, Арьс судлал-1, Дүрс оношилгоо судлал-1 Төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх сургалтад 7 их эмч суралцаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ | | | | | Үүнд:<br>• Ангиограф судсан доогуурх, эмчилгээ оношилгоо эмчилгээ судлал-1<br>• Эх барих эмэгтэйчүүдийн хэт авиан оношлогоо<br>• Нойр булчирхайн хавдрын мэс засал судлал<br>• Компьютер томографи оношилгоо<br>• Эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал-1<br>• Эмэгтэйчүүдийн Дурангийн мэс засал-1<br>• Чих хамар хоолой мэс засал судлал-1<br>Сувилагч тусгай мэргэжилтний төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх сургалтад:<br>-Эрчимт эмчилгээний сувилахуй-1<br>-Сэтгэцийн сувилахуй-1<br>-Чихрийн шижингийн сувилахуй-1<br>-Яаралтай тусламжийн сувилахуй-2<br>-Серологи лаборант-1<br>-Эх барихын дээшлүүлэх-1<br>-Мэс заслийн сувилахуй-3, Нярайн сувлахуй-1, Хүүхдийн сувилахуй-1, нийт төрийн сангийн санхүүжилтээр 12 эмнэлгийн тусгай мэргэжилтэн суралцсан.<br><br>Эрүүл мэндийн салбарын 18 удирдах ажилтанд Ажил олгогч, Удирдах ажилтны сургалтыг зохион байгуулж сертифкат олгосон. ЭМЯ удирдах ажилтны зөвөлгөөнд 2, аймгийн удирдах ажилтны зөвөлгөөнд 99, ХӨСҮТ-ээс зохион байгуулсан Сүрьеэгийн зөвөлгөөнд 2, Тогтвортой хөгжлийн зорилго сургалтад 5, Төвийн бүсийн бүсчилсэн хөгжлийн чуулганд 3, Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд үндэсний сургалтад 100 Эрүүл мэндийн удирдах ажилтнууд хамрагдсан байна. | |
| 3.2.2 | Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, шаардлагатай мэргэжилтнийг улсын төсөвийн санхүүжилт (төрийн сан)-аар сургалтад хамруулна. | 5 сая | Хамрагдсан мэргэжилтний тоо | - | 1-2 | ЭМЯ-наас 2024 оныг Нийгмийн Эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласан ба үүнтэй холбогдуулан Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг, ЭМГ, Ахмад хөгжлийн төв хамтран Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг чадавхижуулах “Нийгмийн эрүүл мэндийн үндэс” 5 хоногийн сургалтыг зохион байгуулж 30 эмч, эмчнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж сертифкат олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХӨСҮТ, ДЭМБ-ийн байгууллагын дэмжлэгтэй талбарын тархвар судлаачийн 2 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтад Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн тархвар судлаач Л.Өлзийжаргал суралцаж байна. | |
| 3.2.3 | Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн чиглэлээр гадаадад богино болон урт хугацааны сургалтад хамруулж чадавхижуулахад дэмжлэг үзүүлж ажиллана | - | - Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | 8 улсад нийт 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн | Гадаадад 6 эмч мэргэжилтэн | Эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх “Тасралтгүй суралцагч-эмч” төсөл хөтөлбөрийн хүрээнд 4 улсад 6 чиглэлээр 7 их эмч, 15 сувилагчийг гадаадад сургалт семинарт хамруулсан. Үүнд:<br>ЭМЯамнаас зохион байгуулсан удирдах ажилтан чадавхижуулах зөвөлгөөнд БНСУ 2, Тайланд улсад 1,<br>БНХАУ-ын ChongQing хотод "Нэг бүс-Нэг зам" тэтгэлэгт олон улсын 3 сарын клиник сургалтанд 1,<br>БНСУ-ын Нурууны мэс засал, Өвдөгний үе солих мэс засал, Робот мэс засал, Гар сарвууны мэс засал, Үений дурангийн мэс засал болон хагалгааны дараах нөхөн сэргээх ,өвдөлт намдаах чиглэлээр гэмтлийн тасгийн 2 сувилагч 21 хоногийн сургалтанд хамрагдсан. Дархан Нэгдсэн эмнэлэг, Монголын Перинатологи нийгэмлэг, Millinnium RDS, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар сургууль хамтран төвийн бүсийн чуулган-2024 “Нярайд амьдрал бэлэглэе” сэдэвт VIII алгоритмын ур чадварын сургалтад 8 эх баригч, хүүхэд, нярайн сувилагч нар хамрагдсаж сертифкат авсан. Япон улсад Нагояа их сургуульд сэтгэцийн эрүүл мэнд, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндээр 3 сарын сургалтанд хамрагдсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын Монгол эмнэлэгт зохион байгуулагдсан 7 хоногийн хугацаатай сургалтад улсын төсвийн санхүүжилтээр өрхийн эмч-1, сувилагч-3, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч-1 суралцсан. Гэмтлийн тасгийн 2 сувилагч БНСУ-д ажлын туршлага солилцох 1 сарын сургалтанд хамрагдсан. | 100 |
| 3.2.4 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог нэмэгдүүлнэ. | 1 сая | Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | - Сургалтын тоо 8, -Эрдэм шинжилгээний хурал 2, | Эмнэлгийн мэргэжилтэн нэгээс доошгүй удаа ёс зүйн | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга сургалтад ЭМГ, ӨЭМТ-55 эмнэлгийн мэргэжилтэн, Цахим орчин дах Кибер аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг ЦГ-тай хамтран зохион байгуулж. сургалтанд ЭМГ, өрхийн эрүүл мэндийн төвийн 48 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -436 эмч, мэргэжилтэн хамрагдсан. | сургалтад хамрагдсан байх | “Хувь хүний хөгжил” сэдэвт сургалтыг Хувь хүний хөгжлийн мэргэжлийн сургагч багш А.Амаржаргалтай хамтран зохион байгуулж 110 эмч хамрагдсан байна. Дэлхийн эмч нарыг угтан салбарын шилдэг Ёс зүйч эмчээр Нэгдсэн эмнэлгийн поликлиник-1р тасгийн дотрын их эмч Г.Мэндбаяр, дүрс оношилгооны их эмч Б.Мөнхзаяа шалгарч урамшуулсан.<br>Нэгдсэн эмнэлэг Ёс зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулж 126 ажилтан хамрагдсан. Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн хэсгийн хорооны дарга Э.Төрмөнх хэвлэл мэдээллийн хэргслээр мэдээлэл түгээсэн.<br>Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн хэсгийн хорооны гишүүд поликлиник-1, хүүхэд, сэтгэц, сүрьеэгийн тасгуудад 3 удаа сургалт хийж 45 хүн хамруулсан.<br>Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан "Ёс зүйн танин мэдэхүй" шилжин явах цом бүхий мини оломпиад зохион байгууллан 12 баг 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.<br>Дархан-Уул аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, АШУҮИС-ийн багш Цэрэнбат “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сургалтад 120 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>Нэгдсэн эмнэлэг нь “Төрийн болон албаны, нууцын хадгалалт хамгаалалтын тухай” болон “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн сургалтыг Дархан-Уул аймгийн Тагнуулын Ерөнхий Газартай хамтран зохион байгуулж байгууллагын удирдлага, тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нар 53 ажилтан хамрагдсан өдөр Ёс зүйн салбар хорооноос Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалтыг өрх, сумын 62 ажилтанг сургалтад хамруулсан.. | |
| **Зорилт 3.3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана** | | | | | | | |
| 3.3.1 | Орон нутгийн эрүүл мэндийн удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэнд олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллана. | - | Урамшууллалд хамрагдсан хувь | Эмч, эмнэлгийн ажилтнуудад улирал бүр гүйцэтгэл | 100% урамшуулал олгосон байх | 2024 оны 11-р сарын байдлаар Эрүүл мэндийн газар 66 ажилтанд 86,4 сая, Нэгдсэн эмнэлэг 580 ажилтанд 1,076.7 сая, Хонгор СЭМТ 26 ажилтанд 57.6 сая, Шарын гол СЭМТ 44 ажилтанд 46.1 сая, Орхон СЭМТ 21 ажилтанд 57.8 сая, Аминхолбоо ӨЭМТ 25 ажилтанд 28.4 сая, ГОС ХОТ ӨЭМТ 50 ажилтанд 159.8 сая, Гэрэлтэй ӨЭМТ 21 ажилтанд 21.8 сая, МЭДС ТОБ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ийг нь үнэлэн журмын дагуу 40-60% хүртэл урамшуулал олгосон. | | ӨЭМТ 29 ажилтанд 95.0 сая, Түвшинхолбоо ӨЭМТ 21 ажилтанд 57.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон буюу нийт 883 ажилтанд 1,686.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.Шагнал:<br>"Хөдөлмөрийн аварга эмч "1, "Алтан гадас" 7, ЭМЯ ЭХТА 16, "Жуух бичиг" 12, Аймгийн "Тэргүүний ажилтан" 16, Аймгийн "Жуух бичиг" 10, Засаг даргын шагнал "Гэгээн дагина" Үйлдвэрчний эвлэлийн "Мөнгөн чагнуур", Шилдэг ёс зүй" "Шилдэг манлайлагч", " Шилдэг шинэ технологч" "Чадварлагч сувилагч" " Манлайлагч сувиагч" Шилдэг зохион байгуулагч" "Залуу үеийг халамжлагч хүмжүүлэгч" "Шилдэг эх баригч" үйлдвэрчний эвлэлийн шагнал-5, эмэгтэйчүүдийн холбооний шагнал-6, залуучуудийн холбооны шагнал-5, Үйлдвэрчний эвлэлээс зохион байгуулсан эрүүл мэндийн салбарын “Санхүү бүртгэлийн ажилтан” “Шилдэг жолооч” шалгарсан. нийт 112 ажилтан шагнал урамшуулалд хамрагдсан байна. | |
| 3.3.2 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах арга хэмжээ хэрэгжүүлнэ | - | орон сууц, гэрээр хангагдсан ажилчдын тоо | 3 | 3-5 | Эрүүл мэндийн байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн хороо санаачлан хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн ажилтны 108 айлын 10 давхар орон сууцны “Health apartment барилгын төсөл”-ийг Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн 4 дүгээр хурлаар хэлэлцэн баталж гэрээ байгуулсан. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр сумын эрүүл мэндийн төвд ажиллагсдын цалин орон нутгийн 40%-иар, 2024 онд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр Эрүүл мэндийн газрын 63 ажилтан үндсэн цалингийн 40%-иар орон нутгийн нэмэгдэл тус тус олгогдсон. | 90 |
| 3.3.3 | Эмч ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эмчлэн | 10 сая | -Үзлэгт хамрагдсан ажилтны тоо | -Урьдчилан сэргийлэх үзлэг оношлого | -750 Ажилтан Эрүүлжилт 68.5% | Нэгдсэн эмнэлэг нь ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийн хуваарь гаргаж, ЭМС-ын 2019 оны А/537-р тушаалын 3-р хавсралтын дагуу шинжилгээнд 470 ажилтан хамрагдаж, В вирустай 16, С вирустай 19 тус тус илэрсэн ба В вирусын дархлал тогтоцыг 520 ажилтнаас авч, дархлал тогтоц 10ml/IU-ээс бага илэрсэн 46 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | | - Эрүүлжилтийн хувь | онд 741 ажилтан хамрагдаж, эрүүлжилт 68.4% | | ажилтанг В вирусийн эсрэг вакцинд хамруулсан. Нэгдсэн эмнэлгийн эмч ажилчдын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх ажил зохион байгуулж 134 ажилтан хамрагдаж 82 ажилчны амны хөндий эрүүлжсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д 356 ажилчид хамрагдсан. Хангалттай сайн А-155/43.51%/, Сайн В-138/38.72%/, Хангалттай С-42/11.75%/, Дунд D-16 /4.52%/, Хангалтгүй F-5 /1.51%/, үнэлэгдсэн.<br>Эмнэлгийн ажилдчыг "Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ"-нд 439 ажилтан хамрагдсан. Төрөлжсөн мэргэжлийн эмчийг томилон эрсдэл бүхий 147 ажилтанг II шатны шинжилгээнд хамруулж эмчилгээ, зөвөлгөө өгч ажилласан бай эрүүлжилт 69,1% байна. | |
| 3.3.4 | Эмч ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, орчин нөхцлийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулна. | 20 сая | - Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалтийн тоо - Зарцуулсан төсөв | - ЭМГ, НЭ, 5 Өрх, 3 сумын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдсан /4 095 000 төг/ | Гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн газар нь Энэ жилдээ Эрүүл жиндээ аяны хүрээнд спортын тэмцээн уралдаан зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн газрын баг тамирчидад эрэгтэй, эмэгтэй тус бүрд нь 2 төрлийн 420.000 төгрөгний хувцас хэрэгсэлээр хангасан. Ажлын байрны орчин , албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд гадна хаалга, үүдний хэсэг, хурлын танхим, коридорын засвар, ширээ сандал шинэчилж нийт 12,865,000 төгрөг зарцуулаад байна.<br>Эмч эмнэлгийн мэргэжилтэн албан хаагчдад эмнэлгийн хос хувцас-14.980.000. Нийгмийн эрүүл мэндийн төвийн ажилчдад сургалт сурталчигаа хийхэд зориулан гадуур өмсөх бомбер-1.820.000. Хяналт шалгалтын хэлтэсийн байцаагч нарт ажлын хувцас-570.000, туслах ажилтнуудад ажлын норм хувцас 553,6 мянга. Нийт 18,935,000.00 төгрөг зарцуулсан.<br>Эрүүл мэндийн газрын ажилтан албан хаагч болон ард иргэдийн ая тухтай үйлчлүүлэх, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд гадна төв хаалганы засвар үйлчилгээг эхлүүлэн 80 сая төгрөгний төсөв зарцуулан засвар тохижилтын ажил үргэлжлэн явагдаж байна.<br>Нэгдсэн эмнэлэг нь 28 нэр төрлийн 10.006.500 төгрөгний хувцас хэрэсэлийн төсвийн захиалга хийсэн. Сутайн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ихэр цэцэг ХХК-аас 4810840 төгрөгний 9 төрлийн 92 ширхэг хамгаалах хувцас хэрэслийг худалдан авалт хийн шаардлагатай тасаг албаны ажилчдадыг хамгаалах хувцас хэрэгсэлээр хангасан. | |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4.1.1 | Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллыг олгоно. | - | гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авах | Улирал бүр 40-60% хүртэл урамшуулал | Гүйцэтгэлээр | 11-р сарын байдлаар Эрүүл мэндийн газар 66 ажилтанд 86,4 сая, Нэгдсэн эмнэлэг 580 ажилтанд 1,076.7 сая, Хонгор СЭМТ 26 ажилтанд 57.6 сая, Шарын гол СЭМТ 44 ажилтанд 46.1 сая, Орхон СЭМТ 21 ажилтанд 57.8 сая, Аминхолбоо ӨЭМТ 25 ажилтанд 28.4 сая, ГОС ХОТ ӨЭМТ 50 ажилтанд 159.8 сая, Гэрэлтэй ӨЭМТ 21 ажилтанд 21.8 сая, МЭДС ТОБ ӨЭМТ 29 ажилтанд 95.0 сая, Түвшинхолбоо ӨЭМТ 21 ажилтанд 57.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон буюу нийт 883 ажилтанд 1,686.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. | 100 |
| 4.1.2 | Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана. | - | Шилэн дансны мэдээлэл | 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 778 мэдээлэл байршуулахаас 734 байршуулсан гүйцэтгэл 98.4% | Шилэн дансны мэдээлэл 98.5% | Шилэн данс хөтлөлт 2024 оны 11-р сарын байдлаар 830 мэдээлэлээс 4 мэдээлэл хугацаа хоцроож 826 мэдээллэж 99,5% байна. | 100 |
| 4.1.3 | Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу | - | Албан бичгийн тоо | 7 удаа зохицуулалт хийлгэх санал хүргүүлсэн | Гүйцэтгэлээр | Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Эрүүл мэндийн сайдад аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийлгэх хүсэлт 3 удаа гаргаж шийдвэрлүүлсэн. Үүнд: ЭМГ 5 удаа, СЭМТ-үүд 2 удаа, Нэгдсэн эмнэлэг 4 удаа төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалт хийлгэсэн байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. | | | | | | |
| 4.1.4 | Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ | Улс, Орон нутгийн төсөв | Өр авлагагүй байх | Нийт өр 2,540.6 сая төгрөг | Өр авлагагүй ажиллах | 2024 онд ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилт 10 сараас бүрэн орж ирээгүй ба 10, 11 сарын гүйцэтгэлийн тооцоог ЭМДХэлтэс гаргаж баталгаажуулж дуусаагүй байна. ЭМДСангаас авах санхүүжилтийн авлагыг 10 сарын байдлаар: Нэгдсэн эмнэлэг 1,149.0, Хонгор СЭМТ 104.6 сая, Шарын гол СЭМТ 226.6 сая, Орхон СЭМТ 84.7 сая, нийт 1,564.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлагатай байна..<br>Өр: Нэгдсэн эмнэлэг 4,095.9 сая, Хонгор СЭМТ 89.6 сая, Шарын гол СЭМТ 258.9 сая, Орхон СЭМТ 88.9 сая, нийт 4,533.3 сая төгрөгийн өртэй байна. Эдгээр өрийг ЭМД-ын санхүүжилтийн авлага болон 11, 12 сарын гүйцэтгэлийн санхүүжилт орж ирсэнээр салбарын хэмжээнд өргүй гарахаар байна.. | 70 |
| 4.1.5 | "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Улсын төсөв | Хуулийн хэрэгжилтийг хангах | 95% | 95% | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бүх байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дээд шатны байгууллагуудаар цахим системээр батлуулж тендер худалдан авалтыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж ажиллаж байна. 2024 оны хувьд 1 өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч А3 сертификатны сургалтад тэнцэж эрхээ авсан тул 2025 оноос ӨЭМТ-үүдийн тендерийг өрхүүд өөрийн байгууллага дээр зохион байгуулах нөхцөл бүрдсэн. | 100 |
| 4.1.6 | Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 100.0 | Хэрэгжилт 100.0 | УТХО 2024-2025 оны шилжих хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эмнэлгийн (Аминхолоо, Гэрэлтэй, Мэдстоб) өргөтгөлийн барилга тус бүр 1,604.4 сая төгрөгөөр төсөвлөгдөж 2024 онд тус бүр 800.7 сая төгрөг батлагдсан ба 1 өрхийн эмнэлгийн эмнэлэг шинээр (15-р баг, Мангирт) барихаар 1,835.4 сая төгрөгөөр батлагдаж 2024 онд 917.7 сая төгрөг батлагдаж барилгын ажил хийгдэж байна. Төсвийн тухай хууль, холбогдох журмын хүрээнд Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ЭМСайдаас эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжиж гүйцэтгэлээр олгогдож байна. | |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 5.1. Нотолгоонд суурилсан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 5.1.1 | Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт бусад дэмжлэгийг Аймгийн Засаг даргын нөөц сан, орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлж ажиллана. | - | Шаардлагатай тоног тоног, төхөөрөмжөөр хангагдсан байдал - Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 104.5 сая төгрөг тоног төхөөрөмж | 100 сая | Орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт бусад дэмжлэгийг аймгийн Засаг дарын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэх хүсэлтийг төсвийн төсөл өгөхөд болон төсвийн жилийн дундуур гаргаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажилласан. 2024 онд байдлаар:<br>Шарын гол сумын ОНХС-аас 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Рентгэн аппаратны тендер зарлагдаж Си Ай Ти ХХК шалгарч суурилуулалт хийгдсэн ба рентген аппаратыг байршуулах өрөөг 15.1 сая төгрөгөөр Шарын гол СЭМТ өөрийн байгууллагын төсвөөр зассан. Аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Кёнги аймгаас эмнэлгийн зориулалттай тоноглолтой автомашин 1 ш хандиваар олгосон ба үнэлгээ хийллгэж 55.0 сая төгрөгөөр үнэ тогтоосон. Гааль дээрээс авч ирэхэд татвар, төлбөрт 4.0 сая төгрөгийг Шарын гол СЭМТ өөрийн төсвөөс зарцуулсан. Шарын гол сумын ОНХСангийн хөрөнгөөр дотрын тасгийн дотоод засал 200.0 сая, Тулга сувиллын гал тогоо, хэвтэн эмчлүүлэгчдийн өрөөнүүдийн засварын 21.0 сая төгрөгөөр тус тус зассан. Аймгийн ОНХСангаар Тулга сувиллын үүдний өрөөний засварыг 51.5 сая төгрөгөөр зассан.<br>Хонгор сумын ОНХС-с 19.5 сая төгрөгийн төрөх өрөөнд болон лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Аминхолбоо ӨЭМТ-д ОНХО-аар Эрүүл аюулгүй орчин төслийн хүрээнд Дархан сумын ЗДТГ, Дархан ус суваг ХК, ДДС ХК хамтран дулааны узель болон хэрэглээний халуун усны засвар үйлчилгээг 16.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Мөн ОНХО-аар гадна дулааны төв шугамыг 17.3 сая төгрөгөөр бүрэн сольж шинэчилсэн. Аймгийн ОНХО-аар 63.3 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж Ай Эм Эс Инженжринг ХХК нийлүүлсэн. ГОС ХОТ ӨЭМТ-д аймгийн ОНХО-аар 5 нэр төрлийн 10 ширхэг 98.3 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлүүлсэн. МЭДС ТОБ ӨЭМТ-д аймгийн ОНХО-аар 75.4 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж Ай Эм Эс Инженжринг ХХК нийлүүлсэн.Аймгийн хэмжээнд архины хамааралтай иргэдэд зориулсан төрийн үйлчилгээг үзүүлэх нэгж байгуулах санаачилгыг аймгийн Засаг дарга Б.Азжаргал гаргаж орон нутгийн санхүүжилтээр “Жаргалтай амьдрал төв”-ийг байгуулан 2024 оны 03 сарын 22-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхэлсэн ба тус төвд архины хамааралтай иргэд эмийн болон сэтгэлзүйн эмчилгээ хийлгэж байна. 25 иргэнд эмчилгээ хийсэн бөгөөд иргэд 21 хоногийн хугацаанд олон улсын минисота загвараар сэтгэл засал, эмийн болон физик эмчилгээ хийж, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчидтэй 6 сарын туршид эргэх холбоотой ажиллаж байна. | |
| **ЭМЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 6.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, цахим бүртгэл, хяналтыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх** | | | | | | | |
| 6.1.1 | Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | - Сургалтын тоо<br>- Хамрагдсан эмч мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн тоо | 270 эмнэлгийн ажилтан, 587 иргэд | - Эмнэлгийн ажилтан 250<br>-1000 иргэн | Эм хангамжийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг ЭМГ-ын даргаар батлагдсан удирдамжийн дагуу ЭЭХХЗГ-ын эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч, ЭМГ-ын эмийн мэргэжилтэн хамтран эмийн жорын маягт, жор бичилт, олголт, эмийн зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх арга зам сэдэв болон эмийн сангийн стандартын хэрэгжилт сэдвээр сургалтыг зохион байгуулсан нийт 60 эмийн сангийн эрхлэгч хамрагдсан.<br>ЭЭХХЗГ-с Эмийн гаж нөлөө бүртгэн мэдээлэх журам 2023 оны А/67 шинэчлэгдэн гарсантай холбоотой сургалт зохион байгуулж 50 эмч, эмзүйч хамрагдсан. Эмзүйч нарыг эмзүй албаны зохион байгуулалт мэргэшүүлэх сургалтад 11 хүн ЭМГ-с албан тоот хүргүүлэн цахимаар суралцах боломжоор хангасан.<br>Буриад Омбол ХХК,Энхийн тун эмийн сантай хамтран АУ-ны доктор,профессор Г.Зулхуу, ЭЗУ-ны доктор,дэд профессор Б.Бадамцэцэг, АУ-ы магистр З.Дэлгэрсайхан нар “Амбулаторийн нөхцөлд хүүхдийн антибиотикийн эмчилгээ” танхимын сургалтыг нийт 65 эмч мэргэжилтэнд зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Лек Сандоз ЭХНБ, ЭХЭМҮТ-ийн чанарын менежер А.Оюунчимэг, Улсын 3-р эмнэлгийн зөвлөх эмч С.Энхтуяа хамтран эмч мэргэжилтнүүдэд “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж” сургалт зохион байгуулж 120 эмч мэргэжилтэн хамрагдсан байна. Эмийн жорын маягт,жор бичилт MNS 5376:2016 стандартын дагуу жороор хангах, жор бичилтийг төлөвшүүлэх,сайжруулах ажлыг шат дараатай зохион байгуулж их эмч нарт стандарт жор бичилтийг хэвшүүлэх видео бичлэг байдлаар мэдээллийг DBS -тэй хамтран бэлдэж хувийн хэвшил болон өрх, сум, нэгдсэн эмнэлгийн 170 эмч нарт цахим хаягаар хүргүүлсэн. Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн<br>мэдээлэл, сурталчилгааг 1200 гаруй иргэдэд хүргэж ажилласан. | |
| 6.1.2 | Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллана. | 400 мян | -Хамрагдсан байгууллага | 37 эмийн санд хийж, 11 төрлийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. | -20 эмийн сан,<br>-7 ЭХНБ | Эрүүл мэндийн газраас тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан 73, ЭХНБ 7 үйл ажиллага явуулж байна. Үүнээс ЭМГ даргын батлагдсан Тусгай зөвшөөрөл бүхий эмийн сан,эм ханган нийлүүлэх байгууллагуудад явцын хяналт үнэлгээ хийх удирдамжийн дагуу Дархан эм ханган нийлүүлэх байгууллага-7 (Азифарма ЭХНБ,Монос ЭХНБ,Еврофарм ЭХНБ,Монфа ЭХНБ,МЭИК салбар Дархан-Уул ЭХНБ ,Өлзий-амгалан ЭХНБ) Орхон сумын 1 эмийн сан ( Анагаах хаус ХХК-ны Орхон эмийн сан) Шарын гол сумын 3 эмийн сан (Данафарм ХХК,Ид шид ХХК,Хайрхан түшиг ХХК) Хонгор сумын -3 эмийн сан (Ашид бадрангуй ХХК-ы Арвин тун эмийн сан,Батмөнхзаяамаа нинжин нөхөрлөл-ийн Амгаланзаяа эмийн сан,Фламинго фарм трейд ХХК-ы Фламинго эмийн сан) нийт 14 эмийн сан, Дархан сумын 32 эмийн санд хяналт үнэлгээ хийж, 14 төрлийн зөвлөмж өгч ажилласан. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа эмийн сангуудын сунгалтын материал бүрдүүлэлтэд арга зүйн зөвлөгөө өгч, 16 эмийн сан сунгалт хийгдсэн байна.<br>2025 онд магадлан итгэмжлэлд орох 10 эрүүл мэндийн байгууллагад ЭМС А412 шалгуур үзүүлэлтийн дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явцын үнэлгээг ЭМТҮХ мэргэжилтнүүд хамтран хийж арга зүйгээр ханган 12 төрлийн зөвлөмж өгч ажилласан. | |
| 6.1.3 | Антибиотик эмэнд тэсвэржилт үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, судалгаа хийж үр дүнг тооцон ажиллана. | - | -Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэдийн тоо<br>-судалгааны үр дүн | -Сургалт 3 удаа, 218 эмнэлгийн ажилтан хамрагдсан,<br>-Антибиотикийн тэсвэржилтийн судалгааг 378 иргэнд Ялгагдсан бактерийн 11 бүлгийн хүрээг тодоройлсон. | -Эмнэлгийн ажилтан 200 Иргэд 250<br>-Антибиотекийн тэсвэржилтийн судалгаа | Антибиотик эмд тэсвэржилт үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, судалгаа хийж дүгнэлт гаргасан. Үр дүн: Антибиотик мэдрэг чанар 378 хүнд ялгагдсан бактерийн 11 бүлэг хүрээ тодорхойлсон. Үүнд: Грамм эерэг коккийн хувьд<br>-ампициллинд 88%,<br>- гентамицинд 55%,<br>-Эритромицинд 82%, ципрофлоксацинд 27%, цефазолинд 30%,<br>-Левомицетинд 45%, нитрофурантоинд 40%, триметопримд 75% тэсвэржилттэй байна.<br>Грам сөрөг савханцар Pseudomnonas нь ампициллинд 100% тэсвэржилттэй байна. | 100 |
| **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** | | | | | | | |
| **Зорилт 7.1. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 7.1.1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд алсын зайн оношилгоо, зөвөлгөө, мэдээлэл солилцох (теле медицин) тусламж үйлчилгээг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлж ажиллана. | - | -телемедицины тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | - 4 программаар зайн оношлогооны үйлчилгээнд 456 зөвлөгөө | -Шаардлагатай тохиолдол бүрт | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд Телемедицин алсын зайн оношилгоог телеграм, viber, Zoom, MnCardio, MOHS.DA.GOV.MN, Axis Hospital Karte зэрэг программыг ашиглан 116 удаа зөвлөгөө мэдээлэл авч ажиллсан.. СЭМТ-тэй 12 удаа зөвлөгөө мэдээлэл солилцон тусламж үйлчилгээний хамрах хүрээг УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ ЭСҮТ, ЦСҮТ, СЭМТ зэрэг эмнэлгүүдтэй хамтран хамрах хүрээг нэмэгдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээлли йг 341 удаа солилцсо н. | | Телемидицинээр холбогдож: ШГТЭ-т 1, УНТЭ 3, ГССҮТ 1 өвчтөн зөөвөрлөсөн. СЭМТ-ээс 12 удаа, ЭХЭМҮТ 9, АӨСҮТ 1 удаа телемидицинээр зөвөлгөө авсан. | |
| 7.1.2 | Эрүүл мэндийн цахим мэдээллийн сангаар иргэдийг эрт илрүүлэгт хамруулж, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | - | - Цахимаар эргэн дуудах тогтолцоо нд хамрагдс ан иргэд | Хөхний эрт илрүүлэг үзлэгт **94.7**% Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт **73**.5% -ийн хамрагда лтай. | Хөхний эрт илрүүлэг үзлэгт **94**%-аас доошгүй<br>Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 73%-иас доошгүй | **Эрт илрүүлэг 2024 оны 10 сараар:**<br>Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт **6704** эмэгтэй хамрагдахаас **4596** буюу 68.5% -ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар буурсан байна. Хавдрын урьдал илэрсэн 198, үрэвслийн эсрэг эмчилгээ 126 хүнд хийгдсэн. Эрт илрүүлгээр хорт хавдар оношлогдсон-3.<br>УХХХ-ын илрүүлгийн дуудах-эргэн дуудах үйл ажиллагаанд **EXCEL google** цахим бүртгэлийн систем хэрэгжиж, 4596 иргэний мэдээллийг програмд бүртгэн мэдээллийн сан үүсгэн ХСҮТ д мэдээлсэн.<br>Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-аас дээш насны **26820** эмэгтэй хамрагдахаас **26097** буюу 97.3% хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар өссөн байна. Умайн хүзүүний эмнэл зүйн үзлэгээр эерэг өөрчлөлттэй гарсан 7 үйлчлүүлэгчийг эмчилгээнд оруулсн ба эрт илрүүлгээр оношлогдсон хавдар байхгүй<br>Элэгний өмөнгийн эрт илрүүлгэ үзлэгт 40-65 насны нийт **29316** иргэн хамрагдахаас **28271** буюу 95.0%-ийн хамрагдсан.<br>В вирус илэрсэн 125 ба 0.4%, С вирус илэрсэн 118 ба 0.4%, Элэгний архаг үрэвсэл 88 ба 0.3%. **Хавдрын үзүүлэлт 2024 оны 10 сарын байдлаар:** Хорт хавдрын шинэ тохиолдол 283. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 тохиолдлоор нэмэгдсэн. Хорт хавдрын улмаас нас барсан тохиолдлын тоо 178. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 тохиолдлоор нэмэгдсэн. Хорт хавдрын шинэ тохиолдлын 20.4% эрт үедээ, 79.6% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хожуу үедээ оношлогдсон. 1236 иргэн хавдрын хяналтанд байна.<br><br>Хөдөлмөр зохицуулалт хийгдсэн хүн 133, хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан 2535, хорт хавдраар эмчлүүлэгчдийн эмчилгээний зардалд 101750976 төг<br>Хөнгөвчлөх тасаг 8 ортойгоор 407 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хими эмчилгээ 14 хүнд полихими эмчилгээнд хамрагдсан. | |
| 7.1.3 | Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ, эмчийн үзлэг, өвчний түүх, цаг авах, шинжилгээ авах, өвчтөн илгээхтэй холбоотой цахим соёлыг төлөвшүүлнэ. | - | Цахим системийн хамралт | -Ehealth программын модуль 90 хувьтай цахимжсан. | 95% | H-INFO3 болон E –Health программын тусламж үйлчилгээний чиглэл бүрээр шинэчлэл хөгжүүлэлтйг хийж Ehealth программын модул 90 хувьтай цахимжсан. Лабораторийн бүх тоног төхөөрөмжийг программ хангамжид холбон ажиллаж байна. Биохими Mindry N600 холболт хийсэн.<br>Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй түргэн шуурхай үйлчлэх зорилгоор цахимаар цаг захиалах, утсаар захиалах, и-монголиа цаг захиалах үйлчилгээг үзүүлдэг байсан бол хөдөлмөрийн чадвар түр алдалтын хуудас цахимжуулсан, ЭМД-ын хөнгөлөлттэй эмийг цахим байдлаар код өгч үйлчилдэг болсон, 2024 онд киоск машин байрлуулан үйлчлүүлэгч өөрөө цаг захиалах, шинжилгээний хариу хэвлэх зэрэг тусламж үйлчилгээг хөнгөвчлөн шийдэж байна. Цахимаар 7 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. | 100 |
| 7.1.4 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулж, шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана. | - | Зохион байгуулсан үйл ажиллагаа | -Сургалтад 110 ажилтан<br>-Цахим гарын үсэг 390 ажилтан | Сургалт 100 ажилтан | Цахим орчин дох кибер аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан. Сургалтад ЭМГ, өрхийн эрүүл мэндийн төвийн 48 эмч эмнэлгийн мэргэжилтэн, НЭ-ийн удирдлага, тасгийн эрхлэгч, ахлах сувилагч 51 ажилтан хамрагдсан байна.<br>Тагнуулын газартай хамтран Төрийн болон албаны, нууцын хадгалалт хамгаалалтын тухай болон “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн сургалтыг зохион байгуулж 39 албан хаагч хамрагдсан байна.<br>Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын хэлтсийн 5 байцаагчаар ажлын байрны чиг үүрэгтэй хамраалтай гүйцэтгэлд Төрийн болон албаны нууцыг задруулахгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байх баталгааг гаргуулсан байна. Аймгийн Аудитын газраас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын тухай, цахим гэмт хэрэг сэдэвт сургалтад ЭМГ-ас 28 албан хаагч хамрагдсан байна. | |
| **Зорилт 7.2 Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхийг бэхжүүлэх.** | | | | | | | |
| 7.2.1 | Эрүүл мэндийн ажилтны статитистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг бэхжүүлнэ. | 200 мян | -Сургалтад хамрагдсан ажилтны тоо | -Сургалт 4 удаа, 113 ажилтан хамрагдсан. | 115 | Тайлангийн эргэн мэдээлэл, гарсан алдаа зөрчлийн талаар цахим сургалтад төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 52 статистикийн бага эмч нар хамрагдсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан ZOOM сургалтад өрх сумын 64 эмч, мэргэжилтэн хамрагдсан. | 100% |
| 7.2.2 | Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана. | - | Сар бүр тогтмол мэдээ өгдөг ЭМБ | 151 ЭМБ-ын мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажилласан. | 90% | Хувийн хэвшлийн 188 Эрүүл мэндийн байгууллагаас цаг хугацаандаа мэдээ ирүүлсэн 158 буюу 84.1%-тай сар бүр утсаар болон цаасан хэлбэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээг авч нэгтгэж, мэдээний чанар үнэн зөв байдал хяналт тавьж, Hinfo-3 болон цахим эрүүл мэндийн шивэлт тулгалт хийж сар бүрийн 3-ны өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж ажилласан. Мөн байгууллагын удирдлага болон аймгийн удирдлагыг сар бүрийн 5-нд статистик үзүүлэлтийг гарган мэдээллээр хангаж ажиллаж байна. | 93% |
| 7.2.3 | Эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана. | 500 мян | -Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрдэм шинжилгээний хурал | 6 удаагийн эрдэм шинжилгээний хуралд давхардсан тоогоор 164 эмч, мэргэжилтэн оролцсон байна. | 2-аас доошгүй удаа | Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан Нэгдсэн эмнэлгийн “Эмнэлзүйн ховор тохиолдлууд - 2024”, “Эрдмийн чуулган - 2024” эрдэм шинжилгээний хуралд 60 их эмч хамрагдсан.<br>Эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээний хурал “Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулъя” уриатайгаар зохион байгуулж нэгдсэн хуралдаанд нийт 13 судалгааны материал, илтгэлийг хүлээн авч хэлэлцүүлсэн ба 34 эмч хамрагдсан.<br>Олон улсын сувилагчийн өдрийг угтан эрдэм шинжилгээний бага хурлыг АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн хурлын танхимд “Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж ба нийгмийн эрүүл мэнд” болон “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар” салбар хуралдаанаар зохион байгуулагдаж хуралд нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11 илтгэл хэлэлцүүлж шалгарсан илтгэгч эмч, сувилагч нарыг цалингийн 15-30%-иар урамшуулсан. “Гэмтэл согог судлалын олон улсын эрдмийн 26-р чуулган”-ыг “Эрүүл мэндийг хамтдаа бүтээе” гэсэн уриан дор зохион байгуулсан ба тус чуулганаас “ШИЛДЭГ ЗАЛУУ ГЭМТЭЛ СОГОГЫН МЭС ЗАСАЛЧ”-аар НЭ-ийн гэмтэл согогийн тасгийн эмч Э. Нямбаатарт шалгарсан байна.<br><br>Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтнүүдийн "Амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эмнэлэг дэх гэнэтийн амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэх зорилго бүхий “ЦЭНХЭР КОДООР ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХЭД БИДНИЙ ОРОЛЦОО” сэдэвт мэргэжлийн ур чадварын дадлага сургуулилтын тэмцээн зохион байгуулж Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын 80 гаруй эмч мэргэжилтэн хамрагдсан байна.<br>Үр дүн: Нийт 5 удаагийн эрдэм шинжилгээний хуралд давхардсан тоогоор 185 эмч, мэргэжилтэн оролцсон байна | |
| **Зорилт 7.3. Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 7.3.1 | Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээ мэдээллийн нууцын аюулгүй байдлыг хангана | - | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 110 | 150 | Дархан-Уул аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран Төрийн болон албаны, нууцын хадгалалт хамгаалалтын тухай”, “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн сургалтыг зохион байгуулж сургалтад ЭМГ-ын 39, НЭ-ийн 51ажилтан хамрагдсан байна.<br><br>Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын хэлтсийн 5 байцаагчаар ажлын байрны чиг үүрэгтэй хамраалтай гүйцэтгэлд Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг гаргуулсан байна.<br><br>Үйлчлүүлэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ЭМДЕГ, НЭ-ийн эмч удирдлагатай 3 талт гэрээ хийж 420 ажилтантай гэрээ байгуулсан.<br><br>Мэдээлэл сүлжээ хариуцсан нууцын ажилтан, байгууллагын нууц хамгаалах ажилтан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.3.2 | Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна | 100.0 мян | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | - Сургалтад 17 албан хаагч | 50 | Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд 2 арга хэмжээний хүрээнд 10 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цахим орчин дах кибер аюулгүй байдал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтуудыг ЦГ-тай хамтран зохион байгуулсан байна. Сургалтанд ЭМГ, өрхийн эрүүл мэндийн төвийн 54 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.<br>Эрүүл мэндийн газарт 27 хяналтын камер ажиллаж байна. Эрүүл мэндийн газрын барилгын дээвэрт ДУА-ын Цагдаагийн байгууллагын 1 ширхэг камер суурлуулсан байна.<br><br>Эрүүл мэндийн газрын албан хаагчдын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 25 компьютерийн кодыг журмын дагуу 6 сарын хугацаанд шинэчлэн ажиллаж байна.<br><br>Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу албан хаагчдын Компьютерийн эмх, цэгц шалгах, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>Дотоод хяналтыг хийж, 5 чиглэлээр 8 төрлийн зөвлөмж өгч ажилласан. Дотоод хяналтанд Эрүүл мэндийн газрын 65 ажилтнаас 45 хүн хамрагдсан байна.<br>Үл тохиролыг газар дээр нь засуулж, зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 7.3.3 | Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана | - | Хэрэгжилийн хувь | 80% | 85% | Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зорилт 21 үйл ажиллагааг төлөвлөж ажилласан. Эрүүл мэндийн салбарт 1655 ажилтан ажиллаж байгаагаас 1380 буюу 83.4% нь эмэгтэйчүүд эзэлж байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.3 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд: Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар чиглэсэн сургалт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж хэрэгжүүлэн ажилласан. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үүднээс 39 ажилтан шинээр ажилд авч үүнээс 6 ажилтан эрэгтэй ба нийт шинээр орсон ажилтанд ажлын байрны дарамт болон шинэ ажилтныг гадуурхан тохуурхах түүнийг үл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэвчих хууль зүйн зохицуулалтын талаар сургалтыг явуулсан. Хөдөөгийн малчин малчин өрхүүдэд явуулын үзлэгийг 62 өрхийн 512 иргэдийг хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох “ Архи, тамхины хор хөнөөл”, “ Амьдралын зөв дадал хэвшил”, “Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтанд хамрагдалтын ач холбогдол” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, гарын авлага брошур 287 ширхэгийг тараасан. Зөв амьдралын хэв маягийг сонгосон эрэгтэйчүүдийг дэмжих зорилгоор нийт 3 удаагийн 56 эрэгтэйчүүдийг сургалтанд хамруулсан. Шар зам хоршоо,зам засварын 1-р хэсэг /Хонгор сум/-ийн нийт 128 эрэгтэй жолооч нарт БЗДХ,ХДХВ/ДОХ-оос сэргийлэх ,эрчүүдийн эрүүл мэнд, стресс менежмент сэдэвт сургалтанд хамруулж,эрүүл мэндийн үзлэг хийсэн. Эрт илрүүлгийн үзлэгт 5126 хүн хамрагдсанаас 1832 эрэгтэйчүүд хамрагдсан нь 35,7%-ийг эзлэж байна Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 86.3% байна. | |
| 7.3.4 | Эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н сарын аяныг өрнүүлж, ажиллах таатай орчин нөхцлийг (гадаад, дотоод) бүрдүүлж ажиллана . | 10 сая | зохион байгуулсан үйл ажиллагаа<br>-хамрагдсан байгууллага, хүний тоо | Сургалтад 63 албан хаагч<br><br>Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд 4.1 сая төгрөг хувцас | 10 ЭМБ | ХАБЭА-н сарын аяны хүрээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллацгаая” уриан дор зохион байгуулсан. Хэрэгжилт- 95%<br><br>-ХАБЭА-ын орон тооны бус зөвлөлийн тушаалыг Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн.<br>-ХАБЭА-ын тухай хуулийн 17.1 дэх заалтын дагуу “Зөв хөтөч” сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан ба сургалтад ЭМГ, ӨЭМТ-ийн 44 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, сертификат олгосон байна.<br>ЭМБ-уудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн албан хаагчийн хувцас хамгаалах хэрэгсэлийн судалгааг гаргасан.<br>ХАБЭА-ын тухай хуулийн 17.1-дэх заалтыг үндэслэн ажил олгогч удирдах ажилтны сургалтыг “Ойгон нөмрөг” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж сургалтад ЭМГ, НЭ, ӨЭМТ, СЭМТ-ийн 18 удирдах албан тушаалтан хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэгдсэн эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн автомашинд ашиглагдаж байгаа хүчилтөрөгчийн баллоны баталгаажилтыг хийлгэх зардалийг төсөвийн төсөлд суулгуулсан.<br>Эрүүл мэндийн газрын 2 давхарын гэрэлтүүлэг, хурлын заалыг бүрэн засварлаж эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулахад аятай тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн газрын үүдний хэсэгт тусгай хэрэгцээт иргэдэд тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, налуу шат шинэчлэн хийж, хаягжуулалт хийсэн. Галын утаа мэдрэгч байршуулсан. Ажилчдын ая тухтай байдлыг хангаж ус цэвэршүүлэгч 2, 3 дугаар давхарт байршуулсан. 1,4 дүгээр давхарын Галын аюулгүй байдлын самбарыг шинэчилсэн, Эрүүл мэндийн газрын аварын 4 болон 2 давхарын хаалганд аваарын гэрэлтүүлэг шинээр суурилуусан байна.<br>2 давхарын цахилгааны аюулгүй байдлын хүрээнд цахилгааны мантаж дахин засварласан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын “Өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлыг төлөвлөгөөг нэгтгэн хэрэгжилтийг гарган АЗДТГ-ын Захирагчийн албанд хүргүүлсэн байна.<br>ЭМБ-уудын албан хаагчдын ажлын байрны стрессийн судалгааг google form ашиглан авсан байна. | |
| 7.3.5 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангана | - | Хэрэгжилийн хувь | -Сургалт-4<br>160 албан хаагч хамрагдсан.<br>-<br>Хэрэгжилийн хувь 85 | 90% | Эрүүл мэндийн газраас Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны судалгааг шинэчлэн гаргаж АХЗХ-т хүргүүлсэн байна. Мөн ХАСХОМ гаргуулан хянан баталгаажуулсан байна. 2024.02.21-ны тайланг гарган АЗДТГ-ХЗХ-албан тоотоор хүргүүсэн байна.<br>Мөн Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комиссын №01, 02 дугаар хуралд оролцсон гишүүдээр гаргуулан программд шивж оруулсан зөрчил үүсээгүй.<br>Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн О.Мөнхтулга Хяналт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалтын хэлтсийн улсын байцаагч орон тоон шилжин ажиллах гэж байгаатай холбогдуулан ХАСУМ гаргуулан хянаж АТГ-т хүргүүлсэн ба ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тул улсын хяналтын байцаагчаар томилгоожуулсан. | |
| 7.3.6 | Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлэх өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлнэ | - | шийдвэрл эсэн өргөдөл, гомдол | Шийдвэр лэлт 100% | Өргөдөл гомдлын 30-аас доошгүй хувийг цахимаар авах | Эрүүл мэндийн газарт хандан ирүүлсэн нийт өргөдөл гомдлын тоо 134. Үүнээс 11:11 төвд ирсэн өргөдөл гомдол 29, бичгээр 105, ажилчдаас ирсэн өргөдөл хүсэлт 73 бүгдийг шийдвэрлэж хариу өгсөн.<br>11-11 төвд ирсэн гомдлууд нь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээр дамжуулан цахимаар ирж байгаа ба хариуг мөн цахимаар хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ** | | | | | | | |
| **Зорилт 8.1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж, хамтын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8.1.1 | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцож ажиллана | - | -гэрээ байгуулан ажилласа н эмнэлэг<br>-Ачаалал хуваалцс ан хувь | Нийт үзлэгийн 19.1%, /Шүд- 70.7%, Эмэгтэйч үүд- 26.6% Хэвтсэн 40.1% 8 Лаборато рид 17.2%/ | 12 эмнэлэг 50% | 655917 үзлэг хийгдсэнээс хувийн хэвшлийн нийт үзлэг 125736 буюу 19.1% эзлэж улсын эмнэлгийн ачааллыг бууруулсан байна. Мөн Шүдний үзлэгийн 73.1%, Эмэгтэйчүүдийн үзлэгийн 24.6%, нийт хэвтсэн эмчлүүлэгчийн 41.5%, Лабораторийн шинжилгээний 18.2%-ийг ХХЭМБ хийж тусламж үйлчилгээ үзүүлэсэн байна.<br>Нийт тусламж үйлчилгээний 19.1-73.1% ачаалал хуваалцаж ажилласан байна.<br><br>НЭ-н Ерөнхий эмчийн А/51 тоот тушаалын дагуу хувийн хэвшлийн болон өрхийн эрүүл мэндийн байгууллагатай ариутгал, хог хаягдалын гэрээ байгуулан Халдвартай хог хаягдал тээвэрлэлт, устгалын гэрээтэй 64 байгууллагын 1500 кг халдвартай хог хаягдал цуглуулан тээвэрлэж устгасан. | 100% |
| 8.1.2 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангана.<br>-Хүний нөөцийн | 500 мян | -Мэдээлэл тавигдсан байдал | Хүний нөөц 90% | Хэрэгжил тийн хувь 95% | Шилэн данс хөтлөлт 100% байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн дагуу хүний нөөц эдийн засаг санхүүгийн талаар ил тод байх шаардлагатай мэдээллийг ЭМГ-ын IT ажилтанд хугацаанд гаргаж өгч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | -Үйл ажиллагааны<br>-Төсөв, санхүүгийн<br>-Мэдээллийн | | -Хэрэгжилтийн хувь | -Үйл ажиллагаа 95%<br>-Төсөв, санхүү 98.2%<br>-Мэдээллийн ил тод 100% | | байгууллагын цахим хуудсанд ил тод болгож ажиллаж байна.<br>-Хүний нөөцийн ил тод байдал 90%<br>-Үйл ажиллагааны ил тод байдал 95%<br>-Төсөв, санхүүгийн ил тод байдал 99.5%<br>-Мэдээллийн ил тод байдал 95% | |
| 8.1.3 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэн, төрийн бус байгууллагын Нийгмийн эгэх хариуцлагыг оролцоог нэмэгдүүлж ажиллана. | - | Хамтран ажилласан ТББ | -17 Төрийн болон төрийн бус, ААНБ тай хамтран ажилласан. | 15 | "ШУГАМАН БҮЖГИЙН ТЭМЦЭЭН"-ийг зохион байгуулж нийт 19 байгууллагын 192 албан хаагчид оролцсон.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Дархан-Уул аймгийн Явган алхалтын холбоо, Дархан-Уул аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газартай хамтран DARKHAN WALKING FESTIVAL Монгол улсад анх удаагаа явган алхалтын замын Олон улсын тэмдэг, тэмдэглэгээний стандарт нэвтрүүлсэн хот болж олон нийтэд сурталчлан таниулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, дасгал хөдөлгөөнийг дадал болгоход уриалах зорилгоор 17 ААНБ-ын 624 ажилтан албан хаагчид, иргэд оролцсон. Эрүүл мэндийн салбараа төлөөлөн 90 ажилтан албан хаагчид оролцож 10000км, 50000км алхалт хийж Алхалтын сертификатаа гардан авсан.<br>Эрүүл мэндийн газар, Хүүхэд гэр бүл хөгжил хамгаалалын газар 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газраас эрт илрүүлэг үзлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн судалгаанд үндэслэн 0-17 насны 201 хүүхдүүдийг эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоонд хамруулсан.<br>• “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд шүд, нүүр амны чиглэлээр үйл ажиллагаа явуулладаг 16 хувийн эмнэлгүүдийн захирлуудтай хамтран ажиллах санал солилцож уулзалт хурлыг зохион байгуулж 98 хүүхдийн шүдийг эмчлэн, эрүүлжүүлсэн<br>Хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн тусламж үзүүлдэг 9 эмнэлэгтэй хамтран “Гарц” арга хэмжээний хүрээнд Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг үзлэгт хамрагдвал зохих | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 328-аас хамрагдсан 324 буюу 98% байна. Үүнээс 54 өвчлөл илэрснийг 77.6% эмчлэн эрүүлжүүлсэн.<br><br>Аймгийн ИТХ, Кёнги аймгийн хамтын ажиллагааны хүрээнд 11 ширхэг суурин, 9 ширхэг өвчтөн өөрийнхөө даралтыг хянах боломжтой даралтын аппаратыг хүлээлгэн өгсөн.<br><br>Алслагдсан багийн айл өрхүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулан, хүртээмжтэй чанартай хүргэх зорилгоор ХХҮГ, ЗДТГ, ЭМГ, НЭ, ӨЭМТ, Монос эмийн сан, Өлзий-Амгалан эмийн сантай хамтран өдөрлөг зохион байгуулж 95 өрхийн 267 иргэд хамрагдсан. | |
| 8.1.4 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэж ажиллана. | 3 сая | -шийдвэрийн тоо<br>-ААНБ тоо | Байгууллага-19<br>Шийдвэр 3 | Шийдвэрийн тоо 3<br>Байгууллага 30 | 2018-2023 онд тусгай зөвшөөрөл олгосон эмийн сангуудын судалгааг гарган УИХ-ын Хяналт шалгалтын түр хороонд хүргүүлсэн.<br><br>2023 шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг 12-12.mn сайтад бүртгүүлэхээр судалгааг гарган өгсөн.<br>Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комисс нь 2024 оны 11 сарын 30 байдлаар 9 удаа хуралдаж 70 байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Үүнд<br><br>1. Шинээр тусгай зөвшөөрөл-20<br>2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгалт-41<br>3. Чиглэл нэмэх-2<br>4. Байршил солих-6<br>5. Нэр солих-1<br>6. Эрх сэргээлгэх-1<br>2023 онд Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар орж шинээр тусгай зөвшөөрөл авсан 8 байгууллагад Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу явцын дэмжлэгт хяналтыг зохион байгуулсан байна. Дэмжлэгт хяналтаар 17 төрлийн зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хангуулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн ортой 12 клиник эмнэлэгт дэмжлэгт хяналтыг хийж 9 төрлийн зөвлөсж өгч, мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан. Эмийн сангуудад дэмжлэгт хяналт үргэлжилж байна. | |
| 8.1.5 | Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлнэ | 1 сая | -Өгсөн зөвлөмж<br>-<br>Хэрэгжилтийн хувь | ХШҮ 4 удаа, дундаж 85.7% Өрхийн дундаж 88.6% ,сумдын дундаж 80.6%, НЭ-87.9% 26 төрлийн зөвлөмж | ХШҮ 4 удаа зөвлөмж Хэрэгжилт 87% | ЭМС-ын 2022 оны А/346 тушаал “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”-ын дагуу Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжаар Эрүүл мэндийн байгууллагуудад 1-3 улирлын ХШҮ хийсэн. ХШҮ-ний 1 дүгээр улирлын дүнгийн дундаж хувь 83.1 % (ӨЭМТ-ийн дундаж 84.9%, СЭМТ-ийн дундаж үнэлгээ 77.6%, Нэгдсэн эмнэлэг 86.5% үнэлэгдсэн.<br>ХШҮ-ний 2 дугаар улирлын дүнгийн дундаж хувь 87.8 % (ӨЭМТ-ийн дундаж 87.6%, СЭМТ-ийн дундаж үнэлгээ 80.8%, Нэгдсэн эмнэлэг 95% )<br>ХШҮ-ний 3 дугаар улирлын дүнгийн дундаж хувь 86 % (ӨЭМТ-ийн дундаж 80%, СЭМТ-ийн дундаж үнэлгээ 77%, Нэгдсэн эмнэлэг 93%) үнэлэгдэж 15 төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 87.6%-тай байна. | 100 |
| 8.1.6 | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллана. | - | -<br>Хамрагдсан ААНБ<br>-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Хяналт хийсэн байгууллагын тоогоор | Тайлант хугацаанд хүнс, орчин, халдвар судлал, хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын 4 чиглэлээр 71 обьектод **төлөвлөгөөт хяналт шалгалт** хийж, ундны усны 14, дотоод орчны агаарын 23, арчдасны 357, хүнсний бүтээгдэхүүний 15, нийт 409 дээж авч шинжлүүлэхэд агаар, ус, хүнсний бүтээгдэхүүний дээж эрүүл ахуй аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан, арчдасны 10.9% нь шаардлага хангаагүй гарсан, шалгалтаар нийт 1117 зөрчлийг илрүүлэн илэрсэн зөрчлийг арилгуулахаар 341 заалттай 20 албан шаардлага өгч, нийт зөрчлийн 68%-ийг арилгуулан албан шаардлагын биелэлтийг 77.1%-тай хангуулсан.<br>76 объектод **төлөвлөгөөт бус шалгалт** хийж, шалгалтын явцад ундны усны 6 дээж, хүнсний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүний 1, гадаргуугийн арчдасны 32, дотоод орчны агаарын 2, нийт 41 дээж авч шинжилгээнд хамруулахад агаар, ундны усны дээж стандартын шаардлага хангасан, арчдасны шинжилгээгээр 5 дээж эрүүл ахуйн үзүүлэлтийн шаардлага хангаагүй тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 1 иргэнд 300.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж, 176982 төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулан, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 15 заалттай албан даалгавар хүргүүлж, биелэлтийг 80%-иар хангуулсан. Төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 537 зөрчил илрүүлэн 334 буюу 62.1%-ийг арилгуулан илэрсэн зөрчлийг арилгуулахаар 125 заалттай хугацаатай 10 албан шаардлага өгч, 110 заалт буюу 88%-тай хэрэгжсэн.<br>21 төрлийн **урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад** нийт 751 обьектыг хамруулж 328 дээж авч шинжлүүлэхэд 303 дээж буюу 92.3% нь стандартын шаардлага хангасан. Ундны усны 7, арчдасны 7, бохир усны 8, хөрсний 3 нийт 25 дээж буюу 7.7%нь стандартын шаардлага хангаагүй байна. Шалгалтаар нийт 2107 зөрчил илрүүлэн 1499 буюу 71.1%-ийг газар дээр нь арилгуулан, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 30 байгууллагад улсын байцаагчийн 256 заалттай албан шаардлага хүргүүлсэн ба биелэлт 67.2%.<br>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад хадгалалтын хугацаа дууссан 93 нэр төрлийн 16.35 кг, 197 ширхэг нийт 2.114.395 / хоёр сая нэг зуун арван дөрвөн мянга гурван зуун ерэн тав/ төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар устгуулсан. | |
| **Зорилт 8.2. Эрүүл мэндийн байгууллагуудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийх, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 8.2.1 | Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой | 50 сая | -Урсгал засвар хийгдсэн ЭМБ-ын | Орон нутгийн 2023 оны төсөвт | - | Хонгор сумын ОНХС-с 19.5 сая төгрөгийн төрөх өрөөнд болон лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвийн гал тогооны хоолны агуулахыг 20 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэн ажиллана. | | тасаг нэгжийн тоо | сумын ЭМТ-дэд 505.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. | | төгрөгөөр, ажилчдын ээлтэй, ая тухтай амрах орчин нөхцөлийг бүрдүүлж 19 сая төгрөгийн төсвөөр тохижуулсан. Эрүүл мэндийн төвийн цогцос хадгалах өрөө болон архивын өрөөг байгууллагын 18 сая төгрөгийн төсвөөр засвар үйлчилгээг хийсэн. Шарын гол сумын Дотрийн тасаг, хүүхдийн тасгийн барилгын дотор засварын ажил 200.0 сая төгрөгөөр ОНХО-аар санхүүжүүлж тендер зарлагдаж засварын ажил хийгдсэн<br>Шарын гол сумын ОНХС-аас 150.0 сая төгрөгөөр хиймэл оюун ухаанд суурилсан Рентген аппарат дагалдах хэрэгсэл, байгууллагын төсвөөр рентген байршуулах өрөөг 15.1 сая төгрөгөөр зассан.<br><br>2024 оны УТХО-нд 2024-2025 оны шилжих хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эмнэлгийн (Аминхолбоо, Гэрэлтэй, МЭДС ТОБ) өргөтгөлийн барилга тус бүр 1,604,400.0 мянган төгрөгөөр төсөвлөгдөж 2024 онд тус бүр 800,700.00 мянган төгрөг батлагдсан ба тендер зарлагдаж гэрээ байгуулсан. Мөн 2024 оны УТХО-нд 2024-2025 оны шилжих хөрөнгө оруулалтаар 1 өрхийн эмнэлэг шинээр (15-р баг, Мангирт) барихаар 1,835,400.0 мянган төгрөгөөр төсөвлөгдөж 2024 онд 917,700.00 мянган төгрөг батлагдсан барилгын явц 50% гүйцэтгэлтэй байна.<br>Шинээр баригдах ӨЭМТ-ын үйл ажиллагаа явуулах шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эд материалын судалгаа, зах зээлийн үнийн хамт АЗДТГазрын НБХэлтсэт хүргүүлсэн байна.<br>ЗД-н хөрөнгө оруулалтаар 5 төрлийн 200.677.740 төгрөгний эмэгтэйчүүдийн дурангийн тоног төхөөрамж дагалдах хэрэгслээр хангагдсан.<br>Шарын гол СЭМТ-д ЭМЯ-наас 1 дуудлагын аютомашин, БНСУ-ын Кёнги аймгаас иж бүрэн тоноглолтой эмнэлгийн зориулалттай автомашин 1 ш хандиваар олгосон.<br><br>УТХО-аар 4 өрхийн эрүүл мэндийн төвд суудлын автомашин, ЭМГ-т УТХО-аар 1 суудлын автомашин, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэгдсэн эмнэлэгт УТХО-оор 2 автомашин, Гос хот ӨЭМТ өөрийн хөрөнгөөр 1 автомашин, Хонгор СЭМТ ОНХС-аас 1, УТХО-аар 1 автомашинаар тус тус хангагдсан байна. | |
| 8.2.2 | Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж ажиллана. | 5 сая | Цахилгааны нөөц үүсгэвэр | Эрүүл мэндийн 10 байгууллагууд цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдал хангагдсан | 10 | Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналт 1 удаа хийж , ЭМБ бүр цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг (10) хангаж ажиллаж байна. | 100 |
| 8.2.3 | Гадаад дотоодын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана. | - | - Хэрэгжсэн төсөл хөтөлбөр, үр дүн | Дезерет ОУБ-аас НЭ-т 73.1 сая төгрөг, ӨЭМТ-д 39.3 сая хандивласан. | 1 | Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах 250 ортой шинэ нэгдсэн эмнэлгийн загварыг Эрүүл мэндийн яам, Сангийн яамны төлөөлөлд танилцуулсан. Эмнэлэг баригдах газрын асуудал шийдэгдсэн.<br>"Re exchange international" ОУБ-тай гэрээ байгуулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн солилцох, харилцан суралцах зорилгоор 2023.03 сараас АНУ-ын Техас эмнэлгийн нярайн их эмч Coors Sarah May нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд урт хугацааны чадавхжуулах сургалтыг зохион байгуулж эхэлсэн.<br>- Жайка ОУБ хамтран "Эмнэл зүйн сургагч багш" бэлгэх сургалт, Дархан Нэгдсэн эмнэлэг, Монголын Перинатологи нийгэмлэг, Millinnium RDS, АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг салбар сургууль хамтран төвийн бүсийн чуулган-2024 "Нярайд амьдрал бэлэглэе" сэдэвт VIII алгоритмын ур чадварын сургалтыг хамтран зохион байгуулсан.<br>АНУ-ын (CMDA) "Christian Medical and Dental Association" нийгэмлэгийн мэргэжилтэнгүүд нярайн зөвлөх эмч Sarah May Coors эмчийн урилгаар хүрэлцэн ирж НЭ, ӨЭМТ 159 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд онол, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дадлагын ажлын байрны сургалтыг 2 өдөр зохион байгуулсан.<br>Солонгос улсын Чүнбүг мужийн Иргэдийн хурлын төлөөлөгч, “Хан” эмнэлэг, “Юбик” ХХК,”Чүнбүг” ЭМШУИС , Сайн дурын үйл ажиллагааны зөвлөх бүрэлдэхүүнтэй баг Дархан-Уул аймагт айлчлал эрүүл мэндийн салбарын удирдлага, төлөөлөгчидтэй уулзалт хэлэлцүүлэг хийсэн.<br>БНСУ-ын “Бүчонь Сэжун” эмнэлгийн хүүхдийн зүрх судасны эмч, мэргэжилтэн Бан Жи Сог Дархан-Уул аймгийн зүрх судасны өвчтэй 22 хүүхдэд үзлэг хийсэн.<br>ОУ-н “Deseret” байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 30 ширхэг тэргэнцэрийг хүлээн авсан.<br><br>Хүүхдэд тохиолдох А бүлгийн В стрептококкийн гаралтай ангина, фарингит, хүүхдийн хэрэх өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажиг өвчлөлийн хувийг бууруулах зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сан, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭМГ хамтран 6-15 насны 24690 хүүхдийг эрт илрүүлэх үзлэгт хамруулж 2239 /9%/ хүүхэд эерэг илэрсэн ба дараагийн шатлалын эмчилгээнд хамруулж ажиллахаар бэлтгэл хангаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээнд МонПЭН, Халдварт бус өвчин, зүрх судасны өвчнөөс сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож ажиллана. 2024 оны 11 сарын 30 ны байдлаар Монпэн-гийн үзлэгт 3 Өрх 5 сум хамрагдвал зохих 65859 үүнээс хамрагдсан 41869/63.5%/ иргэн хамрагдсанаас Артерийн даралт ихсэлт 485 /1.1%/ Зүрх судасны өвчлөл 186/0.4%/ чихрийн шижин 78/0.1%/ тус тус оношлогдож хяналтан авч зөвлөгөө өгч ажилласан байна.<br><br>Дархан сумын төслийн хөрөнгө оруулалтаар Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн сургалтын өрөөний тоног төхөөрөмж 20 сая төгрөг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өрөөний их засвар 3 сая төгрөгөөр тохижуулсан. АЗТГ-ийн НБХ-т " Хавдарын хими эмчилгээг орон нутагт нутагшуулж эмч ажилтанг чадавхижуулах" төслийн хүрээнд 15 сая төгрөгний санхүүжилт авсан байна.Орон нутгийн төслөөр "Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлийг тусгаарлах, хамгаалах, эмчлэх өрөө"-г гэмтлийн тасагт 16,627,000төг-өөр тохижуулж, байгуулсан. Тогтвортой хөгжлийн 3-р зорилт ЭМ-ийг дэмжих хүрээнд оны онцлох төслүүдийг шалгаруулах "Болор сарнай-2023" наадмаас НЭ-ийн Гэмтлийн тасгийн их эмч Э. Нямбаатарын төсөл "Шилдгийн шилдэг Болор сарнайн эзэн"-ээр шалгарч 20 сая төгрөгний үнэ бүхий гэмтлийн үе мөчний иж бүрэн аппарат тоног төхөөрөмж хүлээн авсан. | |

Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 чиглэл , 23 зорилт, 102 арга хэмжээний хэрэгжилт 96.3%-тай байна.

**ТАЙЛАН НЭГТГЭСЭН:**

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ч.МӨНХЦЭЦЭГ

**ТАЙЛАН ХЯНАСАН:**

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЗОЛБАЯСАХ